

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар 3
ҮАГ-ын хоёрдугаар газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл 4
<i>Газрын захирал: Ц.Батбаяр</i>	
<i>Аудитын менежер: Х.Баярмаа</i>	
<i>Ахлах аудитор: Г.Цэдэнбалжир</i>	
<i>Аудитор: Ц.Сугармаа З.Цээнээ Ж.Ядмаа</i>	
<i>Шинжээч: Л.Эрдэнэчулуун Ш.Отгонбаяр</i>	
Нийслэлийн аудитын газар	
<i>Шинжээч: Ч.Нямдорж Д.Эрдэнэчимэг Х.Баасандорж</i>	
2008 оны 6 дугаар сар	
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.pmis.gov.mn	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ:	
Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	
	Бүлэг 1
	Илүү санхүүжилт олгогдож 501.3 сая төгрөг зарцуулагдаагүй үлджээ
	Санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна 5
	Хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах тохиолдол гарсан байна 6
	Хөрөнгийн зарцуулалтыг үнэн зөв тайлагнаж чадахгүй байна 9
	Зөвлөмж 10
	Бүлэг 2
	Бэлтгэн нийлүүлэгчийг хуулийн дагуу сонгоогүй байна
	Журам хуультай зөрчилдөж байна 11
	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн өртгийг хянаж чадахгүй байна 13
	Зөвлөмж..... 15
	Бүлэг 3
	Бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарт тавих эцэг эхчүүдийн хяналт хангалтгүй байна
	Санал асуулгаар сурагч, эцэг эхчүүдийн дийлэнх нь сэтгэл ханамжтай байгаа ч чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүнээр үйлчилсэн тохиолдол гарч байна 16
	Эрүүл ахуйн наад захын жишиг тогтоож, мөрдүүлэх шаардлагатай байна 18
	Бүтээгдэхүүний шаардлага хангаж буй эсэхэд хяналт бүрэн тавиагүй байна 20

Хөтөлбөр хэрэгжүүлснээр сурагчдын эрүүл мэндэд эерэг өөрчлөлт гарсан эсэхийг тооцох боломжгүй байна 21

Зөвлөмж 22

Холбогдох байгууллагын санал

Сангийн яамны Төрийн сангаас ирүүлсэн санал 23

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн санал 24

Нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газраас ирүүлсэн санал 27

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар28

Хавсралтууд:

Хавсралт-1 29
Хавсралт-2 30
Хавсралт-3 31
Хавсралт-4 32
Хавсралт-5 33
Хавсралт-6 34
Хавсралт-7 35

Тушаал 36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
СЯ	Сангийн яам
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
АНБСГ	Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар
БСГ	Боловсрол, соёлын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСЕБС	Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургууль
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ҮЦХ	Үдийн цай хөтөлбөр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БЗД	Баянзүрх дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
БН	Багануур дүүрэг
БХ	Багахангай дүүрэг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ТБӨС	Төрийн бус өмчийн сургууль
БН	Бэлтгэн нийлүүлэгч
ЦС	Цогцолбор сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
АШБ	Анхан шатны бүртгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2008 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хөтөлбөрт зориулан олгосон хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үдийн цайны хүнсний бүтээгдэхүүнийг зохих ёсоор бэлтгэж буй байдал, бэлтгэн нийлүүлэгчийн сонголт, үйлчилгээ болон арга хэмжээ, түүнд тавих хяналтыг үр нөлөөтэй зохион байгуулж байгаа эсэх чиглэлээр шалгаж, холбогдох дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Хамарсан хүрээ

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, Ерөнхий боловсролын сургуулиудын санхүү, үйл ажиллагааны тайлан, судалгаа материалд тулгуурлан “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг 2006, 2007 оны байдлаар шалгав.

Арга зүй

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн тайлан, тоон мэдээ судалгаанд дүгнэлт хийх, аймгуудын Боловсрол, соёлын газрын дарга нар, Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, хөтөлбөрийн ажилтнууд, сурагчид, багш, эцэг эхчүүдтэй ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг судлах, аудитын асуудлаар түүвэрчлэн шалгаж, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх зэрэг арга зүйг ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг ҮАГ-ын хоёрдугаар газар, аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид гүйцэтгэж, ШУТИС-ийн профессор, ТШУ-ны доктор Г.Лхагваа, ЭМЯ-ны харъяа Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, АУ-ны доктор Б.Гэрэлжаргал нар зөвлөгөө өгч ажиллав.

Бүлэг 1

Илүү санхүүжилт олгогдож, 501.3 сая төгрөг зарцуулагдаагүй үлджээ

Оршил

УИХ-ын 2006 оны 66 дугаар тогтоол, МУЗГ-ын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу “Үдийн цай” хөтөлбөрийг 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж иржээ.

“Үдийн цай” хөтөлбөрт 2006 оны сүүлийн хагас жилд Ерөнхий боловсролын 1, 2 дугаар ангийн, 2007 онд 1-4 дүгээр ангийн, 2008 оноос 1-5 дугаар ангийн сурагчид тус тус хамрагдах хуваарьтай юм.

Энэ дагуу уг хөтөлбөрт 2006-2007 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн 109.9 мянга, 2007-2008 онд 187.6 мянган сурагч хамрагдаж, 2006 онд 2.6 тэрбум төгрөг, 2007 онд 9.7 тэрбум, бүгд 12.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.



Санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна

1.1 УИХ-ын тогтоолын дагуу СЯ, БСШУЯ 2006, 2007 оны үдийн цай хөтөлбөрт хамрагдах сурагчдын тоог санхүүгийн жилээр дараахь байдлаар тооцжээ.

Он	БСШУЯ-ны гүйцэтгэлээрх хүүхдийн тоо	Сангийн яам төсөвлөсөн	
		Хүүхдийн тоо	Санхүүжилт (сая. төг)
2006	109'977	109'987	2672.7
2007	187'863	196'081	10000.1

1.2 2006 оны төсөв, түүний гүйцэтгэлд зөрүү гараагүй нь санхүүжилтийг санхүүгийн тайлант жилийн эцэст буюу бодит гүйцэтгэл гарсны дараа олгосонтой холбоотой байна. Харин Сангийн яамны тооцсон 2007 оны хөтөлбөрт хамрагдах сурагчдын тоо, санхүүжилтийн дүн БСШУЯ-наас гаргасан тооноос 8218

хүүхдээр буюу 419.1 сая төгрөгөөр илүү байна.

1.3 Түүнчлэн үдийн цай хөтөлбөрт хамрагдах зарим аймгийн сурагчдын тоо бодитой бус төлөвлөгдсөн байна. Тухайлбал,

- Баян-Өлгий аймаг 2006 онд 564, 2007 онд 507 хүүхдээр
- Булган аймаг 2006 онд 130, 2007 онд 481 хүүхдээр
- Сэлэнгэ аймаг 2006 онд 334 хүүхдээр
- Ховд аймаг 2006 онд 198, 2007 онд 577 хүүхдээр
- Сүхбаатар аймаг 2007 онд 146 хүүхдээр тус тус илүү төлөвлөсөн байна.

Төв аймагт 2007 оны “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтэд 2006-2007 оны хичээлийн жилийн хүүхдийн тоогоор 277.8 сая төгрөг төсөвлөгдсөн нь бодит гүйцэтгэлээс 429 хүүхэд буюу 21.8 сая төгрөгөөр илүү байна. Сангийн яамнаас олгогдсон санхүүжилтээс хуваарилагдаагүй үлдсэн 21.8 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2007 оны 456 тоот захирамжаар сумдын сургуулиудад дахин хуваарилжээ.

1.4 Санхүүжилтийг тооцохдоо 1 сурагчид 1 өдрийн үдийн цайны зардлыг 300 төгрөгөөр бодож, 2007 оны санхүүгийн жилд нийт 10 000.1 сая төгрөг төлөвлөжээ.

1.5 МУ-ыг хөгжүүлэх сангаас аймаг, нийслэлийн төрийн санд 10000.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс 9716.1 сая төгрөг олгогдож, 284.0 сая төгрөг хуваарилагдаагүй үлдэж, 2007 оны эцэст дээрх хөрөнгийг санд эргэн төвлөрүүлсэн байна.

1.6 Аудитад хамрагдсан байгууллагуудад судалгаа хийж үзэхэд үдийн цайны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж олгосон хөрөнгөөс 388 сургуульд 501.3 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна. Энэ нь хүүхдийн тоог илүү тооцсоноос 419.1 сая төгрөг, хичээллэх өдрийн тоог нэг өдрөөр илүү тооцсоноос 58.8 сая төгрөг, нийт 477.9 сая төгрөгийг илүү тооцож, олгосонтой холбоотой байна. Энэ бүхнээс үзэхэд 2007 онд олгох санхүүжилтийг 7.8 хувийн алдаатай төлөвлөжээ. (Хавсралт №1, №2, №3)

Хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах тохиолдол гарсан байна

1.7 СЯ-наас сурагчдын амралт болон баяр ёслолын өдрийг харгалзалгүйгээр санхүүжилтийг сар бүр 1111.1 сая төгрөгөөр тэнцүү хуваарилсан байна. Үүний улмаас сургуулийн санхүүжилт зарим сард илүү, зарим сард дутуу олгогдож, улмаар зарцуулагдаагүй үлдсэн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

1.8 Аудитад хамрагдсан ЕБС-ууд “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 2-т¹ заасныг зөрчиж, “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтээс 195.4 сая төгрөгийг хөрөнгө бэлтгэх, их болон урсгал засвар, үйл ажиллагааны зардал, хандив, бэлэг дурсгал, ойн арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулжээ.

1.9 Үдийн цайны зардлаас 8 аймаг 54.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ.

- Баян-Өлгий аймгийн БСГ 2006 онд хэмнэгдсэн 11.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. БСГ-ын даргаар ажиллаж байсан Т.Тогторхан 46 ширхэг хуучин компьютерийг үдийн цайны санхүүжилтийн хэмнэлтээс шилжүүлэн авсныг хуулийн байгууллага шалгаж байна.
- Архангай аймагт 2007 оны зарцуулагдаагүй 13.4 сая төгрөгийн үлдэгдлээс Эрдэнэбулган сумын Хүмүүн III сургууль 2.5 сая, Хүмүүн I сургууль 1.0 сая, Батцэнгэл сумын сургууль 1.4 сая, Өгийнуурын сургууль 1.4 сая төгрөг, Ирээдүй ЦС 2.7 сая гэх мэтчилэн 17 сургууль эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.
- Баянхонгор аймгийн Номундалай ЦС 1.7 сая төгрөгийг хоолны тогоо авахад зарцуулжээ.
- Булган аймгийн Могод, Орхон, Рашаант сумын сургуулиуд 175.8-2673.4 мянган төгрөг буюу нийт 4.3 сая төгрөгийг эд хогшил худалдан авахад зарцуулжээ.
- Дархан-Уул аймгийн 9 дүгээр сургууль сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад 2.7 сая төгрөг зарцуулжээ.
- Өвөрхангай аймгийн Баянгол сумын сургууль 2575.4 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авах, байр тохижуулахад зарцуулсан бол, Нарийнтээл сумын сургууль 700.0 мянган төгрөгөөр номын сангийн ширээ сандал, 256.4 мянган төгрөгөөр хөрөө рам, Арвайхээр сумын 1 дүгээр сургууль 420.0 мянган төгрөгөөр буузны жигнүүр, 205.0 мянган төгрөгөөр хуушуур шарагч, 309.5 мянган төгрөгөөр гурил зуурагч, 250.0 мянган төгрөгөөр угаалгын машин, 350.0 мянган төгрөгөөр хөргөгч, 300.0 мянган төгрөгөөр 10 ширхэг усны сав зэргийг худалдан авчээ.
- Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын сургууль 4.6 сая, Жаргалант сум 2.1 сая,

¹ “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”

Рашаант сум 2.9 сая, Хатгал сум 1.3 сая, Ринченлхүмбэ сум 1.8 сая, Эрдэнэбулган сум 1.1 сая төгрөг гэх мэтчилэн нийт 14.7 сая төгрөгийг хөрөнгө бэлтгэхэд зарцуулжээ.

- Дундговь аймгийн Сайнцагаан сумын Д.Эрдэнэболд захиралтай 2 дугаар сургууль 555.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, ус буцалгагч, О.Оюунханд захиралтай 3 дугаар сургууль 245.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, М.Сэрсэндэмид захиралтай 4 дүгээр сургууль 93.0 мянган төгрөгөөр ус буцалгагч, 10 ширхэг халуун сав, бүгд 893.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ.

1.10 Хоёр аймаг их болон урсгал засварт 30.4 сая төгрөгийг зарцуулжээ. Тухайлбал:

- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2007 оны 10 дугаар сарын 15 өдрийн 236 тоот захирамжаар Хар хорин сумын 1 дүгээр дунд сургуулийн гадна дулааны шугам засварт 10.0 сая төгрөг, Өлзийт сумын сургуулийн засварт 6.6 сая төгрөг, Хайрхандулаан сумын хүүхдийн цэцэрлэгийн засварт 7.1 сая төгрөг гэх мэтчилэн нийт 29.7 сая төгрөгийг үдийн цай хөтөлбөрийн хэмнэгдлээс зарцуулахаар шийдвэрлэж, зарцуулсан байна.
- Дархан-Уул аймгийн 15 дугаар сургууль урсгал засварт 1.4 сая төгрөг зарцуулжээ.

1.11 Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтээс 10 аймаг 98.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

- Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүмүүн I сургууль 1444.5 мянга, Цэнхэр сумын сургууль 1028.2 мянга, Цэцэрлэг сум 960.0 мянган төгрөг гэх мэтчилэн 5 сургууль бүгд 4311.6 мянган төгрөгийг дотуур байрны хүүхдийн хоолонд зарцуулсан.
- Баянхонгор аймгийн Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Түдэвваанчиг, төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нарын шийдвэрээр 2007 онд ирсэн үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтээс Баян-Өндөр суманд 1000.0 мянга, Баацагаан суманд 1200.0 мянга, Заг суманд 1300.0 мянга, бүгд 3500.0 мянган төгрөгийг сургуулийн өрийг барагдуулахад, Номгон ахлах сургууль 1300.0 мянга, Эрдэнэмандал ахлах сургууль 1900.0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагаандаа тус тус зарцуулжээ.
- Баян-Өлгий аймагт 2006 онд 2200.0 мянга, 2007 онд 11400.0 мянган төгрөгийн үдийн цайны зарцуулагдаагүй үлдэгдлийг Өлгий, Буянт, Дэлүүн сумдын сургуулиуд үдийн цай бэлтгэх өрөө тохижуулах, хэрэгцээт сав суулга угаагуур худалдан авахад зарцуулсан, Сагсай, Дэлүүн сумын ахлах сургуулиуд 1-2 үйлчлэгч ажиллуулж хөлсийг нь олгожээ.
- Булган аймгийн Сэлэнгэ, Баян-Агт, Орхон, Хутаг-Өндөр зэрэг 7 сум 3912.6 мянган төгрөгийн урсгал зардал, Хутаг-Өндөр, Рашаант сумын сургуулиуд 973.6 мянган төгрөгийн сальфеткийн үнийг үдийн цайны зардлаас гаргажээ.
- Дархан-Уул аймгийн 15 дугаар сургууль урсгал засварт 1400.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 2600.0 мянган төгрөг зарцуулсан. Мөн аймгийн ЗДТГ-ын СЭЗБЗХэлтэс Дархан сумын 1 дүгээр сургуулийн 763.9 мянга, Шарын голын 6 сургуулийн 862.1 мянган төгрөгийн үлдэгдлийг татан авч бусад байгууллагын өр авлагыг барагдуулахаар шилжүүлэн зарцуулсан.
- Өвөрхангай аймгийн Орхон ЦС албан томилот, ном хэвлэл, сургалт, уралдаан тэмцээний зардалд 3269.2 мянган төгрөг, Нарийнтээл сумын сургууль багш нарын тээврийн зардалд 118.3 мянган төгрөг, Хайрхандулаан сумын сургууль аарц, сүү, цайны печень зэрэг үдийн цайны хүнсний бүтээгдэхүүнийг хувь хүнээс авч 145.0 мянган төгрөгийг хүн амын орлогын татварт тус тус шилжүүлэн зарцуулжээ.
- Сэлэнгэ аймгийн Хашаат сумын 11 жилийн сургуулийн захирал Г.Батдорж 902.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд, Сант сумын сургуулийн захирал Б.Даваа 611.2 мянган төгрөгийг урьд оны өр дарахад тус тус зарцуулжээ.
- Төв аймагт зарцуулагдаагүй үлдэгдлээс Архуст, Батсүмбэр, Баянчандмань, Бүрэн, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант сумд дотуур байрны хүүхдийн хоол,

сургуулийн урсгал болон их засвар, шинэ жилийн баярын бэлэг, дотуур байрны тохижилт, үдийн цайны аяга, таваг бусад материал зэрэгт бүгд 15695.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

- Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Хатгал сумдын сургууль бүгд 29.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.
- Хэнтий аймгийн Хан Хэнтий ЦС 341.6 мянган төгрөг, Тэмүүжин ЦС 647.1 мянган төгрөг, Жаргалтхааны сургууль 388.0 мянган төгрөгөөр жижиг эд хогшил худалдан авсан, 1 дүгээр сургууль 7133.1 мянган төгрөг, Хан Хэнтий ЦС 494.0 мянган төгрөг, Тэмүүжин ЦС 2127.7 мянган төгрөгийг тус тус сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолонд, Тэмүүжин ЦС 737.8 мянган төгрөгийг түрээсийн төлбөрт, 2847.1 мянган төгрөгийг хичээл практикийн зардалд тус тус зарцуулжээ.

1.12 Үдийн цайны санхүүжилтийн үлдэгдэл, сурагчдад олгогдоогүй үдийн цайны мөнгөнөөс 6 аймаг 8.5 сая төгрөгийг хандив, ойн арга хэмжээ, бэлгэнд зарцуулжээ.

- Дархан-Уул аймгийн 15 дугаар сургууль үдийн цайны санхүүжилтийн үлдэгдлээс “Миний монгол цэцэрлэгт хүрээлэн” байгуулахад 400.0 мянган төгрөгийн хандив өгсөн.
- Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр сургууль үдийн цайны санхүүжилтийн хэмнэгдлээс сурагчдад 629.2 мянган төгрөгийн бэлэг олгожээ
- Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сургууль 2007 оны 9 дүгээр сард 5 өдөр 7 бүлгийн 220 хүүхдэд үдийн цай олгоогүйгээс хэмнэгдсэн мөнгөөр шинэ жилийн баяраар захирлын тушаалаар 396.0 мянган төгрөгийн бэлэг өгчээ. Тус аймгийн БСГ-ын дарга болон мэргэжилтний ам шийдвэрээр Баян-Агт, Бугат, Тэшиг зэрэг 9 сумын сургууль 7350 хүүхэд/өдөр буюу 2186.4 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хичээлд ирээгүй сурагчдад нөхөн олгож, Хутаг-Өндөр сумын сургууль 2007 оны 1, 2 дугаар сард 3, 4 дүгээр ангийн 133 хүүхдэд 27 хоног олгоогүй 1089.0 мянган төгрөгийг хүүхдүүдэд бэлнээр өгчээ.
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 11 жилийн сургуулийн захирал Б.Батмөнх 1390.8 мянган төгрөгийг сургуулийн 70 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан, Цагаан нуур сумын 11 жилийн сургуулийн захирал Г.Сугар хэмнэлтийн 936.6 мянган төгрөгийг сургуулийн хөдөлмөрийн кабинетыг тохижуулахад зарцуулсан байна.
- Ховд аймагт Үдийн цайны санхүүжилтийн үлдэгдлээс Жаргалант сумын Цаст–Алтай ЦС 282.7 мянган төгрөг, 11 жилийн 3 дугаар сургууль 450.3 мянган төгрөг, 11 жилийн 1 дүгээр сургууль 785.1 мянган төгрөг, Манхан сумын сургууль 2034.8 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулжээ.
- Өмнөговь аймгийн төвийн 4 дүгээр сургууль 4 өдөр 452 хүүхдэд 542,4 мянган төгрөг, 1 дүгээр сургууль 11 өдөр 342 хүүхдэд 1126.2 мянган төгрөг, бүгд 1668.6 мянган төгрөгийг бэлнээр тараасан байна.

1.13 Үдийн цай хөтөлбөрт зориулж олгогдсон хөрөнгөөс 4 аймаг 20233 хүүхэд/өдөрт ногдох 6.5 сая төгрөгийг үдийн цайд олгоггүй сурагчдыг хохироосон байна. Үүнд:

- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 2007 оны 1 дүгээр сард 3-4 дүгээр ангийн 116 сурагчдад 4 өдрийн 145.0 мянган төгрөгийн үдийн цайг ямарч шалтгаангүй олгоогүй байна.
- Булган аймгийн Баян-Агт сумын сургууль 2007 оны 1, 2 дугаар сард 3, 4 дүгээр ангийн 75 сурагчид 19 өдөр, Дашинчилэн сумын сургууль 3-4 дүгээр ангийн 85 сурагчид 29 өдөр, Хишиг-Өндөр сум 2006 онд 3 өдөр, 2007 онд 5 өдөр, 1 дүгээр сургууль 2007 оны 3, 4 дүгээр ангийн 379 сурагчид 19 өдөр, нийт 12387 хүүхэд/өдөр буюу 3527,6 мянган төгрөгийн үдийн цайг олгоогүй байна. Мөн Сэлэнгэ сумын сургууль 2008 оны эхний 4 сард 5 дугаар ангийн 59 хүүхдэд 61 өдөр үдийн цай өгөөгүйгээс 3599 хүүхэд/өдөрт ногдох 1439.6 мянган төгрөгийн үдийн цай олгогдоогүй байна.
- Дундговь аймгийн Өндөршил сумын Н.Мөнхцэцэг захиралтай сургууль 2008 оны 1-5 дугаар сар хүртэлх хугацаанд 5 дугаар ангийн 28 хүүхдийг 79 өдөр үдийн цай

хөтөлбөрт хамруулаагүйгээс 2212 хүүхэд/өдөр буюу 884.8 мянган төгрөгийн үдийн цай олгогдоогүй байна.

- Дархан-Уул аймагт хувийн хэвшлийн гадаад хэлний сургалттай 19 дүгээр сургууль 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хичээллээгүй атал 107 хүүхдийн санхүүжилт 32.1 мянган төгрөгийг тооцож авсан, мөн 2007 оны 1 дүгээр сард 3 ангийн 85 хүүхдэд 17 өдрийн 433.5 мянган төгрөг, бүгд 465.6 мянган төгрөгийн үдийн цай олгоогүй байлаа.
- Налайх дүүргийн 109 дүгээр сургууль мөн хичээлийн жилд 5 дугаар анги, 2007 онд 3, 4 дүгээр ангийн сурагчдыг 1, 2 дугаар сард хөтөлбөрт хамруулаагүй байна.

Хөрөнгийн зарцуулалтыг үнэн зөв тайлагнаж чадахгүй байна

1.14 “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 10.2², “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17.1.10³-т заасныг зөрчиж, үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд үлдэгдлээр тусган харуулаагүй зөрчил аудитад хамрагдсан ихэнх байгууллагад нийтлэг байна. Мөн түүнчлэн:

- Аймгийн БСГ-ууд үлдэгдлийг бууруулж тайлагнасан,
- Сургуулийн захирал, нягтлан бодогч нар бэлтгэн нийлүүлэгчид урьдчилан шилжүүлсэн зардлаа тайлан, бүртгэлд тусгаагүй,
- Журналын ирцийн болон үдийн цай түгээлтийн бүртгэл хоорондоо зөрүүтэй,
- Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг үдийн цай хөтөлбөрт зарцуулсан мэтээр тайлагнасан,
- Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг санхүүгийн тайланд төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, төсвийн зарцуулалттай нэгтгэж тайлагнасан зөрчил нилээд байна.

○ Төв аймгийн БСГ-ын нэгтгэсэн тайлангаар (дарга Ч.Цэцгээ, эдийн засагч П.Баярсайхан) Үдийн цайны санхүүжилт, зарцуулалтыг санхүүгийн тайланд тусгахдаа зарцуулалтыг 25062.0 мянган төгрөгөөр илүү тусгаж энэ дүнгээр үлдэгдлийг бууруулсан байна. Борнуур сумын сургууль 6076.7 мянган төгрөг, Зуун мод сумын 5 дугаар сургууль 1529.4 мянган төгрөгийг тус тус бэлтгэн нийлүүлэгч байгууллагад илүү шилжүүлж, тайлан тэнцэлд авлагаар харуулаагүй байна.

○ Багануур дүүргийн “Боловсрол” ЦС-ийн нягтлан бодогч П.Амарсайхан 2006 оны санхүүжилтээс “Бадрах дэлгэрэх” ХХК-д илүү шилжүүлсэн 455.8 мянган төгрөгийг авлагаар тусган харуулалгүй хүнсний материал авснаар тооцон НББ-ийн бичилт хийж, үлдэгдэлгүй гаргасан.

○ Баянхонгор аймгийн Баянцагаан сумын сургууль, Ганмөнхжин ХХК-д материалын үнэ нэрээр 1400.0 мянган төгрөг, Номгон ахлах сургууль Хонгорын шим хоршоонд 450.0 мянган төгрөг, Санаачлага хоршоонд 591.2 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй байна.

○ Булган аймгийн Тэшиг сумын сургууль 71.7 мянган төгрөг, Хутаг-Өндөр сумын сургууль 403.0 мянган төгрөг, Эрдмийн өргөө ЦС 1900.7 мянган төгрөг, бүгд 2375.4 мянган төгрөгийг тус тус бэлтгэн нийлүүлэгчдэд илүү шилжүүлжээ.

○ Дорноговь аймгийн 1 дүгээр сургуулийн нярав 2007 оны 11 сарын бараа материалын тайланг нэгтгэж гаргаагүй байхад нягтлан бодогч нь бэлтгэн нийлүүлэгчид зардлыг урьдчилан шилжүүлж байжээ.

○ Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль 703.8 мянган төгрөгөөр,

² “баталсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан тэнцэл гарган ... үнэн зөв мэдээллэр хангах”,

³ “Байгууллагын санхүүгийн тайланг үнэн зөв гаргах”

Баянгол сумын 4 дүгээр сургууль 563.4 мянган төгрөгөөр тус тус үдийн цайны зардлын гүйцэтгэлийг тайлан тэнцэлд илүү тусгасан байна.

- Дархан-Уул аймагт “Үдийн цай” хөтөлбөрийн АШБ, НББ хангалтгүй байна. 15 дугаар сургууль 1311.9 мянган төгрөг, Жигүүр ЦС 4081.3 мянган төгрөгийг гэрээт байгууллагад үндэслэлгүй шилжүүлсэн байна.

- Нийслэлийн 42 сургуульд түүвэрчилсэн байдлаар 3-10 хоногийн журналын ирцийн бүртгэлийг үдийн цайны түгээлтийн бүртгэлтэй тулган үзэхэд 9749 хүүхэд/өдрийн зөрүү гарч байна. Үүнийг нэг хүүхдэд ногдох зардлаар тооцвол 2924.7 мянган төгрөгийн зөрүү гарч байна.

- Завхан аймгийн БСГ 2006 оны үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг санхүүгийн тайланд төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, төсвийн зарцуулалттай нэгтгэж тайлагнасан нь хөтөлбөрийн хөрөнгийн орлого, зарцуулалтыг тусад нь гаргаж, дүгнэх боломжгүй болгожээ.

1.17 “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитаар аймгийн аудитын байгууллагуудаас давхардсан тоогоор 323 сургуульд 336.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 171.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн байна. Үндэсний аудитын болон нийслэлийн аудитын газраас 8 дүүргийн 57 сургуульд зарцуулагдаагүй үлдэгдлийг эргүүлж төлүүлэхээр бүгд 119.8 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, аудитын явцад 116.6 сая төгрөг буюу 97.3 хувийг барагдуулав. АНАГ, ҮАГ-аас хийсэн аудитаар нийт 627.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 282.5 сая төгрөгийг МУХС болон улсын төсөвт оруулаад байна. *(Хавсралт №4)*

1.18 Аудит хийх явцад СЯ-ны Төрийн сангийн газрын дарга С.Мягмардаш гарын үсэг зурсан 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдөр 5-7а/2626 дугаар албан бичгийг⁴ аймаг, нийслэл, дүүргийн төрийн сан болон Эдийн засгийн бодлого зохицуулах хэлтэст явуулсан. Энэ бичиг болон Үндэсний аудитын газар, аймаг, нийслэлийн аудитын газруудаас тогтоосон төлбөрийн актыг үндэслэн аудитад хамрагдсан болон хамрагдаагүй сургуулиудын зарцуулагдаагүй үлдэгдлийг Монгол Улсыг хөгжүүлэх санд буцаан төвлөрүүлж байна. 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар энэ санд нийт 276.3 сая төгрөг төвлөрүүлээд байгаа бөгөөд үүний 237.9 сая төгрөг нь 2008 оны 5 дугаар сарын 20-ноос хойш (97 сургуулиас) аудитын явцад оржээ.

Зөвлөмж: БСШУ-ны сайд Н.Болормаад:

- “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлийг зохицуулах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран журамлах.

Сангийн сайд Ч.Улаанд:

- Тухайн жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хүүхдийн шилжилт хөдөлгөөн, ирц, сургуулийн дотоодод хийсэн хичээлийн зохицуулалт зэргээс хамаарсан төсвийн хэмнэлт, хэтрэлтийг харгалзан “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөгөө, хуваарьт тодотгол хийж байх.

⁴ “... МУХС-аас 2007 онд олгосон “Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдлийг Монголбанк дахь 3402118003 дансанд 2008 оны дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ үү”

Бүлэг 2 Бэлтгэн нийлүүлэгчийг хуулийн дагуу сонгоогүй байна

Оршил

БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дүгээр тушаалаар батлагдсан “Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам” /цаашид “**журам**” гэх/-д хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэрээт гүйцэтгэгчийг сонгоход баримтлах шалгуурыг тусгажээ.

Журам хуультай зөрчилдөж байна

2.1 Дархан-Уул аймгийн Тендерийн комисс 2006 онд тендер зарлаж, төвийн 17 сургуулийн үдийн цайны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 4 бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ хийсэн байна.

2.2 Дээрхээс бусад аймаг, нийслэлийн ЕБС-ын захирлууд хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1 дэх заалтыг⁵ мөрдөөгүй, харьцуулалтын аргыг хэрэглэлгүйгээр журмыг баримталж шууд гэрээ байгуулсан байна.

2.3 Журмын 1.2-т “зориулалтын гал тогоогүй тохиолдолд сургуулийн захиргаа хүнс хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах замаар тус тус зохион байгуулна”, мөн журмын 1.3-т “Сургуулийн захирал аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг 2-3 сарын хугацаатай байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэсний үндсэн дээр сунгах эсэхээ Хяналтын комисстой хамтран шийдвэрлэнэ” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай зөрчилдөж байна.

2.4 ЕБС-иудад үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэх зарим гэрээний нөхцөл, хугацаа, бүтээгдэхүүний үнэ, өртөг, илчлэг, эрүүл ахуйн шаардлага, гэрээг дүгнэх, хариуцлага тооцох асуудал тодорхой бус байна.

2.5 Нийслэлийн сургуулиуд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанаас бүтээгдэхүүн нийлүүлэгчээ сонгож, гэрээг улирал, жилээр хийж, бүтээгдэхүүнээ авч байгаа боловч ихэнх сургуулиуд гэрээгээ дүгнэж ажиллаагүй байна. Алслагдсан зарим сумдын сургуулиуд иргэд болон барааны захаас хүнсний бүтээгдэхүүнийг ямар нэгэн гэрээгүй нийлүүлж байгаа нь журмын 1.5-д “Хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно”, мөн журмын 5.1-д “Үйлдвэр явуулах зөвшөөрөлтэй, Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх” гэж заасныг зөрчиж байна. Жишээлбэл:

⁵ “. . . 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх”

- Завхан аймгийн Баянтэс, Баянхайрхан, Ургамал, Завханмандал, Цэцэн-Уул Түдэвтэй зэрэг сумд хувийн дэлгүүрээс гурилан бүтээгдэхүүн худалдан авч байна.
- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль 2007 онд хувь хүнээс бүтээгдэхүүн худалдан авч байсан.
- Булган аймгийн 20 сургууль гэрээгүйгээр сумын төвийн дэлгүүр болон Улаанбаатарын Нарантуул зах, Орхон аймгийн Хангайн бүс, Есөн-Эрдэнэ зах болон хувь хүмүүсээс хүнсний бүтээгдэхүүн худалдан авч байна.
- Улаанбаатар хотын Томбат ХХК нь Талхчихэр ХХК-ийн бүтээгдэхүүнийг дүүргүүдийн сургуулиудад дамжуулан хүргэж байна.
- Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль 2007 онд 189 хүүхдийн үдийн цайг сургуулийн цайны газрыг түрээсээр ашиглаж байгаа иргэн Б.Оюундэлгэр, О.Энхтуяа нартай гэрээ хийж, олгуулжээ. Дээрх 2 хүнтэй 2006 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр гэрээ хийсэн боловч гэрээг улирал бүр шинэчлэх, сунгах, дүгнэх ажил огт хийгдээгүй байна. Тогооч нар ч эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамрагдаагүй байв. Тус сургуульд хяналтын зөвлөл байхгүй бөгөөд цайны газрын үйл ажиллагаа хангалтгүй, хоолны амт чанар муу, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа талаар нэр бүхий 23 хүн гарын үсэг зурсан саналыг 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдөр сургуулийн захиргаанд өгч байсан боловч байдал өөрчлөгдөөгүй байна.

2.6 Аймаг дүүргийн зарим засаг дарга нар ЕБС-ийн захирлуудын бэлтгэн нийлүүлэгчээ өөрсдөө сонгох, гэрээгээ дүгнэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцоход нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Баянгол дүүргийн 13, 20, 46, Монгени ЦС-иудын бэлтгэн нийлүүлэгчээр Кокодесерт ХХК, Бенедакт ХХК, Мон сүү ХХК, Тэгшсайхан хүсэл ХХК, Вачиндра сар ХХК-иудыг сонгосон гурвалсан гэрээг дүүргийн Засаг дарга П.Цогтбаатар баталсан байна. Эдгээр гэрээнд гэрээг дүгнэх, хариуцлага тооцох талаар ямарч заалт тусгагдаагүй байна.
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Л.Найдангийн 2006 оны 291 дүгээр захирамжаар дүүргийн ЕБС-уудын бэлтгэн нийлүүлэгчээр Сүү ХК-ыг томилсон байна.
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 сургуулийн өмнөөс сумын Засаг дарга УБ хотын Сүү ХК, Шимт хараа ХХК-тай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан байна.
- Увс аймгийн Шинэ ирээдүй ЦС, Увс шилтгээн ХХК-тай 2008 онд хийсэн гэрээний 6, 7 дугаар заалтад “Хичээл тасалсан” сурагчдын цайны санхүүжилт нийлүүлэгч буюу Б талд үлдэнэ “ гэсэн нь төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчмыг зөрчжээ.
- Дархан-Уул аймгийн Поликом ХХК гэрээгээр нийлүүлэх тарагны оронд чацарганы шүүс, Дархан сондор ХХК сүүний оронд үзэмний шүүс нийлүүлж, гэрээгээ зөрчиж байжээ.

2.7 Зарим албан тушаалтан хувийн ашиг сонирхолд нийцсэн гэрээ хийж байна.

- Говь-Алтай аймгийн Эрдмийн өргөө ЦС-ийн цайны газрыг 2006 оны 9 сараас нягтлан бодогч С.Мягмарсүрэн түрээсээр ашиглаж байна.
- СХД-ийн Төрийн сангийн хэлтэст төсвийн эдийн засагчаар ажилладаг Б.Янжиндулам тус дүүргийн 104 дүгээр сургуульд 2006 оны 1 дүгээр сараас нягтлан бодогчоор давхар ажиллаж байна. Түүнчлэн 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд үдийн цай олгох ажил жил бүрийн 5 дугаар сарын 25-наар зогсч, санхүүжилт тухайн сардаа дуусдаг атал СХД-ийн Төрийн сангийн хэлтсээс 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 66 тоот шилжүүлгээр 1218,1 мянган төгрөг шилжсэн байна.
- Дундговь аймгийн Адаацаг сумын сургуулийн захирал С.Баяраа төрсөн дүүтэйгээ гэрээ байгуулан ажиллаж байна.
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1, 2 дугаар сургууль, Мэргэд ЦС-ийн захирлууд үдийн цайнд нийлүүлэх бүтээгдэхүүнийг Өнө хонгор ХХК, Голден бридж ХХК-тай гэрээ байгуулан ажиллажээ. Гэтэл Өнө хонгор ХХК-ийн захирал нь тус сумын Засаг дарга Т.Гончигдоржийн гэр бүлийн хүн, Голден бридж ХХК-ийн захирал нь БСГ-ын Б.Мөнхжаргалын хүү, Мэргэд ЦС-ийн бага ангийн сургалтын менежер нь БСГ-ын даргын гэр бүлийн хүн байна.

2.8 Дээр дурдсан үйлдлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2⁶, Төрийн албаны хуулийн 15.1.11⁷ -т заасныг зөрчжээ.

2.9 Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нартай байгуулсан гэрээг аудитад хамрагдсан сургуулиуд дүгнээгүй байгаа нь журмын 1.3, 6.3.2 дахь заалтуудыг зөрчиж байна.

Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн өртгийг хянаж чадахгүй байна

2.10 Сургуулиудад нийлүүлж байгаа үдийн цайны хүнсний бүтээгдэхүүний орц, өртөг, үнийг сургуулийн захирлууд тэр бүр хянахгүй байна. Аудитад хамрагдсан зарим сургуульд үйлдвэрлэгч байгууллагуудаас нийлүүлж байгаа бүтээгдэхүүний өртөг, жин хэмжээг тооцож үзэхэд дараахь байдал ажиглагдлаа. Үүнд:

- Бенедакт ХХК сурагчдын үдийн цайнд 4 нэр төрлийн 179 төгрөгийн нэгжийн өртөг бүхий жимсний шүүс нийлүүлж байна. Чихрийн агууламжийг багасгаж чадвал аминдэмээр баялаг байгалийн цэвэр бүтээгдэхүүнээр хийсэн эдгээр бүтээгдэхүүн эрүүл мэндэд сайн юм. Тус үйлдвэрийн ажлын байрны дүгнэлтэд архи, ликёр, жимсний шүүс, чанамал гэж бичсэн атал улсын бүртгэлийн гэрчилгээнд жимсний шүүс үйлдвэрлэх талаар нэмэлт бичилт хийгдээгүй байв. Тус үйлдвэр 34 сургуулийн 28377 хүүхдэд үйлчилдэг бөгөөд өдөрт 794,5 мянган төгрөг, сард 17480,2 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үдийн цайнд нийлүүлдэг.
- “Эвтэй Намсрай” ХХК нийслэлийн 36 сургуульд 3 төрлийн шүүс, 14 төрлийн гурилан бүтээгдэхүүн (70 гр) нийлүүлдэг. Бүтээгдэхүүний нэгжийн өртөг 2008 оны 5 дугаар сарын 9-ны байдлаар 133.20-140.00 төгрөг гэж тооцоолсноос үзэхэд тус үйлдвэр нэгж бүтээгдэхүүний өртөг дээр 2007 онд 10-16.80 төгрөг, 2008 онд 60-66.80 төгрөгийг нэмж борлуулдаг байна. Өөрийн бүтээгдэхүүндээ эрүүл ахуй, найрлага, орцын шинжилгээ хийх боломжгүй (лаборатори байхгүй) үйлдвэрт эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй ажилчид ажиллаж байна. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэж буй түүхий эд (гурил, масло, варень, сүүн крем, дрож, хуурай сүү г.м)-ийг захаас шууд худалдан авдаг, тэдгээр нь шинжилгээний бичиггүй байлаа.
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 11 жилийн 1, 2, 3 дугаар сургууль, Хантайшир–Эрдэм ЦС-иудын үдийн цайнд өгч байгаа гурилан бүтээгдэхүүний илчлэгийн

⁶ Өөрийн ажил үүргийн дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно”

⁷ Албан тушаал эрхэлдэг төрийн байгууллагад, эсвэл шууд удирдлага, хяналтад нь ажилладаг байгууллагад гурав дахь этгээдийн төлөөлөгч буюу итгэмжлэгдсэн этгээд байхыг хориглоно”

хэмжээнд аймгийн МХГ-ын лабораториор шинжилгээ хийлгэж, улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахад бүтээгдэхүүний илчлэг, жин ойролцоо боловч үнэ нь харилцан адилгүй байна.

- Баянгол дүүргийн 78, 28 дугаар сургуулийн гэрээт нийлүүлэгч Кокодесерт-ХХК-ийн цайны боов 90 грамм байхаас 60 грамм, шинэлэг тэргүүн боов 85 грамм байхаас 62 грамм, Монгени сургуулийн нийлүүлэгч Монбатжил ХХК-ийн жимстэй кекс 45 грамм байхаас 30 грамм болж, бүтээгдэхүүнүүд нь 15-30 граммаар дутуу, 28 дугаар сургуулийн гэрээт нийлүүлэгч Дабль-Эрдэнэ ХХК-ийн хоормог 130 грамм байхаас 110 грамм болж, 20 граммаар дутуу байжээ.
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Шимт хараа ХК 50 грамм жинтэй боов 200 төгрөгөөр нийлүүлэх ёстой боловч дээж авч үзэхэд 25 грамм байжээ. Сайхан сумын Хөтөлийн 11 жилийн сургуулийн бэлтгэн нийлүүлэгч Цээлийн гол ХХК БНХАУ-д үйлдвэрлэсэн мах орлуулагчаар хоол хийж өгч байгаа нь үдийн цайгаар авбал зохих үндсэн шимт бодис илчлэгийн хэмжээг зөрчсөн байна.
- Ховд аймгийн Жаргалан сумын 1 дүгээр сургуулийн үдийн цайнд өгч байгаа бүтээгдэхүүний үнийг тооцоход 1 хүүхдэд ногдох бүтээгдэхүүний бодит зардал 129 төгрөг байжээ. Үүнээс үндэслэн 2006 онд 3992.4 мянган төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч талд илүү олгосон гэж үзэж болохоор байна.
Мөн аймгийн төвийн 11 жилийн 1 дүгээр сургуульд 2008 оны 5 сарын 5-ны өдөр бэлтгэн нийлүүлэгч Лут-Очир ХХК-ны мушгиа боов, үзэмний шүүсийн дээжээс МХГ-ын шинжилгээнд хамруулахад байвал зохих нормативаас уураг 1.24, нүүрс ус 14.24, илчлэг 70.4 гр-аар дутуу байна.
Аймгийн төвийн 11 жилийн сургуульд Лут-Очир ХХК-ны 2008 оны 5 дугаар сард нийлүүлсэн боовны 14 хоногийн өртгийг тооцож үзэхэд 1 кг боорцогны зах зээлийн үнэ 900 төгрөг, нэг хүүхдэд өгч байгаа 88 гр боорцогны үнэ 79 төгрөг 20 мөнгө, үзэмний шүүс 150 төгрөг, бүгд 229.10 төгрөг болж, нэгж бүтээгдэхүүнээс 170 төгрөг 90 мөнгө буюу тухайн өдөрт 143,4 мянган төгрөг, 14 хоногт 2008.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн дутуу нийлүүлсэн бөгөөд 2, 3, 6 дугаар сургууль, Прогресс дунд сургуульд бүгд 7345,7 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг дутуу нийлүүлсэн байна.



2.11 Энэ бүхнээс үзэхэд хүнсний үйлдвэрүүдийн үдийн цайнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өөрийн өртөг УИХ-ын 2006 оны 47, ЗГ-ын 2008 оны 45 дугаар тогтоолуудаар баталсан үдийн цайны зардлын хэмжээнд хүрэхгүй байна.

2.12 Үдийн цай нийлүүлж байгаа байгууллагуудад зарим сургуулийн удирдлага багш нарын баяр, сургуулийн ой, анги танхимын барилгын засвар зэрэгт хөрөнгө мөнгөний туслалцаа, дэмжлэг авах талаар санал хүсэлт тавьдаг байна. Тухайлбал, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн захирал С.Одмандах 2008 оны 4 дүгээр сарын 23-нд "...Манай сургууль нь 1 давхрын шалны засварын ажил хийх гэж байгаа бөгөөд уг засварын ажилд 10.0 сая төгрөг шаардлагатай байна...гэрээнд заасны дагуу холбогдох санхүүгийн бодит тусламж үзүүлж өгөхийг хүсэж албан бичиг хүргүүлэв" гэсэн бичгийг Атар-Өргөө ХК-д хүргүүлж байжээ.

Зөвлөмж: БСШУ-ны сайд Н.Болормаад:

- БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын тушаалаар баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөж буй журмын холбогдох заалтыг ТБОНӨХБАҮХАТХуульд нийцүүлэх арга хэмжээ авах,
- Хөтөлбөрийн хүрээнд бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч нартай байгуулах гэрээнд тавигдах шаардлага, гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх.

Бүлэг 3

Бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарт тавих эцэг эхчүүдийн хяналт хангалтгүй байна

Оршил

Журамд хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах, үдийн цайнд олгох хүнсний бүтээгдэхүүнд болон цэс зохиоход тавигдах шаардлага, хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих, тайлагнах талаар тусгасан байна.

3.1 Сургуулийн хүүхдүүдэд үдийн хоолыг хэрхэн олгодог талаар зарим орны туршлагыг судалж үзэхэд:

- АНУ-д эцэг эхчүүд өөрсдөө хүүхдийнхээ төлөө хариуцлага хүлээх үүрэгтэй учраас төрөөс санхүүжилт гаргаж, үдийн цай, хоол өгдөггүй байна.
- БНХАУ-д айл бүр нэг хүүхэдтэй учир эцэг эх өөрсдөө үдийн хоолыг бэлтгэж, боож өгөөд явуулдаг.
- БНСУ-д зөвхөн хөдөө орон нутгийн бага ангийн хүүхдийн хоолны тодорхой хувийг төрөөс санхүүжүүлдэг байна.

БНСУ-ын жишээ:

Үдийн хоолонд бага, дунд, ахлах ангиуд бүгд хамрагдах ба олгох хэлбэр нь:

- Сургууль өөрийн цайны газарт,
- Гадны болон ТББ-тай гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

Хяналтыг 2 хэлбэрээр буюу:

- Дотоод хяналтыг багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөл хэрэгжүүлнэ.
- Хөндлөнгийн хяналтыг Мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.


Санхүүжилтийн хэлбэр:

- Хоолны үнийг суралцагчдын эцэг эх хариуцах,
- Орон нутгийн сургуулиудын бага ангийн сурагчдын зардлыг төрөөс хариуцах.
- ЗГ, хот, дүүргийн захиргаанаас цайны газрын тоног төхөөрөмж бэлтгэн өгдөг.
- Цайны газарт мэргэжлийн тогооч, хоол зүйчийг ажиллуулна. Ажиллуулахдаа тогтмол бус хугацаагаар ээлжлэн ажиллуулдаг.
- Үдийн хоолны талаар хуульчилсан байдаг.

3.2 Үүнээс үзэхэд нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тодорхой хувийг төрөөс санхүүжүүлдэг, аль эсвэл эцэг эх хүүхдийнхээ хоол ундыг хариуцах ёстой гэж үздэг бөгөөд төрөөс бүрэн хэмжээгээр санхүүжүүлдэггүй байна.

Санал асуулгаар сурагч, эцэг эхчүүдийн дийлэнх нь сэтгэл ханамжтай байгаа ч чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүнээр үйлчилсэн тохиолдол гарч байна

3.3 Аудитын явцад ҮЦХ-өөр өгч байгаа бүтээгдэхүүн таалагддаг уу? гэсэн асуулгад 39805 сурагчид хариулсны 91 хувь, 3278 багш хариулсны 87 хувь, 6683 эцэг эхийн төлөөлөл



оролцож 78 хувь нь “Тийм” гэж хариулсан байна. (Аудитын явцад авсан санал, асуулгын нэгтгэсэн дүнг Хавсралт №5, №6, №7-оор үзүүлэв)

3.4 Үдийн цайнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүний амт, чанарт нийт сурагч, эцэг эхчүүдийн дийлэнх хэсэг нь сэтгэл ханамжтай байгаа ч журамд тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, хүнсний бүтээгдэхүүний амт, чанар шаардлагын хэмжээнд хүрээгүй зөрчил гарч байна.

- Сэлэнгэ аймгийн Мандал сумын сургуулиуд Сүү ХК-ийн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотоос галт тэргээр зөөдөг, энэ нь замдаа гашилж мууддаг, зарим өдөр тасалддаг, нэг төрлийн бүтээгдэхүүн дагнан хэрэглэдэг учир сурагчид идэх дургүй болох тохиолдол гарч байжээ.
- Хөвсгөл аймгийн “Хөвсгөл хүнс” ХК, “Хэрлэн” ХХК-ийн нийлүүлсэн гурилан бүтээгдэхүүн амт чанар муу, түлэнхий, хатсан, “Титаник” ХХК-ийн үйлдвэрлэсэн талх нарийн боов, мах махан бүтээгдэхүүн стандартын шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
- БЗД-ийн 21 дүгээр сургуульд хатсан боорцог, иссэн таргаар үйлчилж байсныг зарим эцэг эх, хүүхдүүд тодорхой баримтаар хэлж байв.
- Баянхонгор аймгийн сургуулиудад нийлүүлэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүн хил гаалиар орж ирэхдээ лабораторийн шинжилгээнд хамрагдсан гэдэг үндэслэлээр аймгийн чанар стандартын итгэмжлэгдсэн байгууллагаар шинжлүүлээгүйгээс чанартай бүтээгдэхүүн хүүхдийн хоол, хүнсэнд хэрэглэж байгаа гэж үзэх боломжгүй байна.

3.5 Үдийн цайнд олгож байгаа бүтээгдэхүүн сурагчдын эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн, амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан байх шалгуурыг хангаж буй эсэхийг хянаж байгаа байгууллага, сургууль алга байна. Үүний улмаас,

- Сургуулиуд дан нүүрс усаар баялаг гурилан бүтээгдэхүүн, чихэрлэг ундааны зүйл үдийн цайнд өгч, эрүүл хүнсээр хангадаггүй,
- Сургуулиудад хоол зүйч мэргэжлийн хүн ажилладаггүйгээс хүүхдүүдэд зөв, эрүүл хооллолтыг хэвшүүлж байгаа эсэх нь тодорхойгүй,
- Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний жин, үнэ, өртөг хэмжээний талаар сургуулийн захирал болон холбогдох хүмүүсийн мэдлэг хангалтгүй байна.

3.6 Үдийн цайны хөтөлбөрт зориулан Төв аймгийн Эрдэнэ сумын сургууль өөрсдийн хүчээр хүнсний ногоо тариалж, орон нутгийн байгалийн баялаг, жимс жимсгэнээр төрөл бүрийн ундаа хийж өгч, журмын 4.5-д заасныг хэрэгжүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж ирсэн байна.


Аймаг, нийслэлийн 610 сургуульд хийсэн судалгаагаар 56.2 хувь нь сүү, 59.3 хувь нь тараг, 64.0 хувь аарц, 3.1 хувь нь хоормог өгч байгаагаас үзэхэд сүү сүүн бүтээгдэхүүн түлхүү хэрэглэх заалт бүрэн хэрэгжихгүй байна.

3.7 Журмаар үдийн цайнд олгохыг хориглосон бүтээгдэхүүнийг зарим сургууль сурагчдад олгожээ. Тухайлбал:

- Дархан-Уул аймгийн Шарын голын 6 дугаар сургууль цөцгийтэй вафль 6014 ш, шоколад 80 ш, торт 80 ш, печень 3839 ш, шоколадтай печень 4506 ш, зөөлөн чихэр 10 кг, бамбар чихэр 1658 ширхэгийг тус тус олгосон.
- Завхан аймгийн Цэцэн-Уул, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Баянтэс, Асгат зэрэг сумдын сургуулиуд үдийн цайнд импортын вафль, супер контик зэрэг чихэрлэг ихтэй бүтээгдэхүүнийг лабораторийн дүгнэлтгүй олгосон байна.
- Булган аймгийн сургуулиудад үдийн цайнд олгож байгаа бүтээгдэхүүний 33,0-20,9 хувьд чихэрлэг бүтээгдэхүүн /печень/ олгосон байна.
- Говь-Алтай аймагт аудитад хамрагдсан 12 сургуульд дээрх журмаар хориглосон бүтээгдэхүүн өгч байжээ.
- Архангай аймгийн сургуулиудын үдийн цайнд олгосон хүнсний бүтээгдэхүүний цэсэд шоколад, болон чихэрлэг зүйл орсон байна.
- Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан сумын сургууль печень, вафли, диско, контик зэрэг чихэрлэг бүтээгдэхүүнийг түлхүү хэмжээгээр өгч байжээ.
- Хэнтий аймгийн сургуулиудад журмаар хориглосон бүтээгдэхүүн өгөх, түлэгдсэн, хүйтэн хоолоор үйлчлэх, мөн хадгалах хугацаа хэтэрч, чанар байдал алдагдсан бүтээгдэхүүн нийлүүлэх тохиолдол гарсан байна.

3.8 Аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд 12 аймгийн 66 сургууль чихэр, 11 аймгийн 37 сургууль зайрмаг, шоколад, Архангай аймгийн 6 сургууль вафли, Говьсүмбэр аймгийн 1 сургууль кофе өгсөн нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг мөрдөхгүй байгааг харуулж байна.

3.9 Аудитын явцад сурагч, багш, эцэг эхчүүдээс авсан санал асуулгаар “Нэг төрлийн бүтээгдэхүүн олон удаа өгдөг үү” гэсэн асуултад 38459 сурагчдын 58 хувь, 3317 багшийн 43 хувь, 6516 эцэг эхийн 51 хувь “Үгүй” гэж хариулсан байна.




3.10 Цэсэд орсон бүтээгдэхүүний нийцэл, зохицлыг зөв сонгоогүй, нэг төрлийн бүтээгдэхүүн долоо хоногт олон давтаж олгож байгаа асуудал нийтлэг гарчээ. Тухайлбал:

- Ховд аймагт үдийн цайнд олгож байгаа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, амт чанар муу,
- СХД-ийн “Ирээдүй” цогцолборын “Ирээдүй” бага ангийн нэр бүхий 15 багш “Томбат” ХХК-ийн нэг төрлийн дан гурилан бүтээгдэхүүнийг хичээлийн жилийн турш өгдөг учир хүүхэд уйдаж, идэх сонирхолгүй болж, зарим хүүхэд хаяж байна гэжээ.

Эрүүл ахуйн наад захын жишиг тогтоож, мөрдүүлэх шаардлагатай байна

3.11 Үдийн цайг өгч байгаа орчны эрүүл ахуйн байдалд сурагч, эцэг эхчүүдийн дийлэнх хувь нь сэтгэл ханамжтай байгаа боловч бодит байдал дээр эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.



3.12 Аудитын явцад хийсэн судалгаагаар аудитад хамрагдсан 580 сургуулийн 190 сургууль буюу 33 хувь нь үдийн цайг сургуулийн гал тогоонд бэлтгэдэг. Нийт сургуулийн 10 хувь нь сургуулийн хоолны газарт буюу тусгайлан тохижуулсан өрөөнд үдийн цайг өгдөг байна. Тухайлбал:

- Увс аймгийн Өлгий, Бөхмөрөн сумын сургуулиуд сургуулийн цайны газарт.
- Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан сумын сургууль үдийн цайг уухад зориулсан тусдаа өрөө бэлтгэж өгсөн. Баянгол сумын сургууль үдийн цайг дотуур байрны хооллох танхимд.
- Төв аймгийн Эрдэнэ сумын сургууль үдийн цайг уухад зориулсан тусдаа өрөө тохижуулсан.
- Баян-Өлгий аймгийн Алтай сумын Баянхадын бага сургууль, Дэлүүн сумын Болашах бага сургуулиуд үдийн цайг дотуур байрны хооллох өрөөнд, Буянт сумын ахлах сургууль тусгай өрөө гарган засвар хийж тохижуулан үдийн цай уух цагийн хуваарийг гаргаж үйлчилдэг байна.

3.13 Дээр дурдагдсанаас бусад сургуулиуд журмын 2.2-т заасны дагуу сурагчдад үдийн цайг ангид нь өгдөг байна.

3.14 Журмын 2.4⁸, 6.3.5⁹ дахь заалт сургууль бүрт харилцан адилгүй хэрэгжиж байгаа нь дараахь үндсэн шалтгаантай байна. Тухайлбал:

Гар угаах нөхцөл бүрдээгүй.


- Нийслэлийн СХД-ийн 65, 67, 104, 105, 107, БЗД-ийн 85, 87, 88, БГД-ийн 47, Номт бага сургууль, Багануур дүүргийн “Боловсрол” цогцолбор, хөдөөгийн сумдын ихэнх сургуулиуд дулаан, халуун, хүйтэн усны холболтын системд холбогдоогүй, материаллаг бааз хангалттай бусаас шалтгаалан сурагчдын гар угаах нөхцөл бүрдээгүй байна.
- Баян-Өлгий аймгийн ихэнх сургуулиуд савангүй усаар гар угаалгаж байна.

Сургуулиуд эмчээр бүрэн хангагдаагүй

- Аудитад хамрагдсан зарим сургуульд, ялангуяа суралцагсдын тоо 900-аас илүүгүй сумдын сургуулиудад эмч ажиллахгүй байгаагаас үдийн цай олгох болон бүтээгдэхүүний эрүүл ахуйд тавих хяналтыг сумын хүн эмнэлгийн эмч, сувилагчдад хариуцуулан зохицуулж байна. Тухайлбал: Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Хөвсгөл, Хэнтий, Орхон аймгийн ихэнх сумдын бага сургуулиуд, БЗД-ын 85 дугаар сургуульд эмч ажиллахгүй байна.
- Нийслэлийн сургуулийн эмч нар бүтээгдэхүүний дээж авах, устгах ажиллагааг бүртгэх талаар хангалтгүй ажиллаж байна.

3.15 Дээрх байдлаас үзэхэд үдийн цай олгох орчны эрүүл ахуйн нөхцөл бүрэн хангагдаж чадаагүй бөгөөд сургууль бүр нөхцөл байдалдаа тохируулан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

3.16 Аудитын явцад авсан санал асуулгад оролцсон сурагчид, багш, эцэг эхийн төлөөллийн 20-37 хувь нь үдийн цай өгдөг эрүүл ахуйн орчин хангалттай бус гэж үзэж байгаа бөгөөд эцэг эх, багш нарын зүгээс



⁸ “Үдийн цай уухын өмнө хүүхэд бүрийн гарыг угаалгах”

⁹ “Үдийн цайны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд сургуулийн эмч, хичээлийн эрхлэгч, хяналтын комиссоос тус тус хяналт тавьж байх”

зориулалтын байранд үдийн цайг өгүүлэх саналыг тавьж байна.

3.17 Үдийн цайны бүтээгдэхүүнийг бэлтгэх, хүлээн авах, хуваарилах ажиллагаа, хадгалах өрөө, байрны наад захын жишиг тодорхой болоогүй байна.

3.18 Үдийн цай хөтөлбөрийг зохион байгуулан хэрэгжүүлж байгаа албан тушаалтан, хяналтын зөвлөлийн хариуцлага, идэвх санаачлагагүй байдлаас шалтгаалж хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын бус өрөө, тасалгаанд хадгалах, хүнсний бүтээгдэхүүний түгээлтийг бохир орчинд явуулах, сургууль дээр дахин савлагаа хийх зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал, Багануур дүүргийн Боловсрол ЦС-ийн үдийн цайны түгээлт хангалтгүй, сургуулийн коридорт тоостой бохир орчинд бүтээгдэхүүнийг хүлээн авч түгээсэн, БЗД-ийн Шавь ЦС дээр дахин савлагаа хийж байв.


3.19 Орон нутгийн сургуулиуд өөрийн гал тогоог түшиглэн үдийн цайг бэлтгэж байгаа боловч тэдгээрт ажиллагсдын мэргэжил, ур чадвар дутагдалтай байна. Ийм байдал Завхан, Өвөрхангай аймгийн сумдын сургуулийн цайны газар болон бэлтгэн нийлүүлэгчийн үйл ажиллагаанд түгээмэл илэрчээ.

3.20 БЗД-ийн 53, 87, 88, Эрэл дунд сургуулийн цайны газрын ажилтнууд эрүүл мэндийн шинжилгээнд тогтмол хамрагддаггүй, эрүүл мэндийн дэвтэргүй бөгөөд хүнсний захаас бүтээгдэхүүнээ авч байна.

Бүтээгдэхүүний шаардлага хангаж буй эсэхэд хяналт бүрэн тавиагүй байна

3.21 Сургуулийн зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар эцэг эхчүүдэд хэлбэр төдий танилцуулж байгаагаас эцэг эхчүүд хөтөлбөрийн хэрэгжилт, олгож буй бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа байдалд хяналт тавьж чадахгүй байна.

3.22 Сурагчдын ар гэрийнхэн болон багш нараас авсан асуулгын дүнгээс үзэхэд 34 хувь буюу 2330 хүн Үдийн цайгаар олгож буй бүтээгдэхүүн болон үйл явцад эцэг, эхийн зүгээс хяналт тавьдаггүй гэжээ. Тухайлбал, асуулгад оролцсон сурагчдын эцэг эхээс Баянхонгор аймагт 58,3 хувь, Ховд аймагт 50,0 хувь, Дундговь аймагт 48,5 хувь, Говь-Алтай аймагт 46,0 хувь нь хяналт тавьдаггүй гэсэн дүн гарч байна. Харин нийслэлийн дүүргийн сургуулиудын сурагчдын эцэг эхчүүдээс авсан асуулгаар 85 хувь нь хяналт тавьдаг гэж хариулжээ.



3.23 Сургуулийн захиргаанаас сурагчдын эцэг эхэд хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж байх талаархи журмын 6.7 дахь заалт ч бүрэн хэрэгжихгүй байна. Сурагчдын эцэг эхчүүдээс “Үдийн цайны үйлчилгээний талаар сургуулийн захиргаанаас та бүхэнд танилцуулж байна уу?” гэсэн асуулгад нийт эцэг эхчүүдийн 61,0 хувь нь танилцуулдаг гэж хариулжээ. Харин асуулгад оролцогчдоос Баянхонгор аймагт 73,0 хувь, Булган аймагт 68 хувь, Говь-Алтай, Дундговь, Хөвсгөл аймагт 54-57 хувь, нийслэлийн дүүргүүдэд 4-13 хувь нь сургуулийн захиргаанаас эцэг эх нарт танилцуулдаггүй гэжээ.

3.24 Журмын дагуу сургуулийн захирлын шийдвэрээр хяналтын зөвлөл байгуулж байгаа боловч эцэг эхийн төлөөллийг оруулаагүй, зөвлөл байгуулсан шийдвэргүй, хяналтын

зөвлөл байгуулаагүй сургуулиуд ч байсаар байна. Тухайлбал, БЗД-ийн 88, 21 дүгээр сургууль, Дорноговь аймагт хяналтын зөвлөл байгуулсан шийдвэргүй, эцэг эхийн төлөөлөлгүй, Булган аймгийн 14 сургууль, Багахангай дүүргийн “Хангай” ЦС, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Уянга сумын сургуульд хяналтын зөвлөл ажиллуулаагүй, Хөвсгөл аймгийн сургуулиуд хяналтын зөвлөл дэх эцэг эхийн төлөөлөлд найдан өөрсдөө хяналт тавихгүй байна.

3.25 Сургуулийн захирал, аймаг, нийслэлийн БСГ-аас “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг улирал бүрийн эцэст гаргаж БСШУЯ-нд танилцуулж байх журмын заалт бүрэн хэрэгжээгүй, БСШУЯ-наас ҮЦХ-ийн хэрэгжилтийн байдлыг улсын хэмжээгээр нэгтгэн дүгнэж тайлан гаргаагүй байна.

3.26 Мөн Баян-Өлгий аймгийн сумдын болон Булган, Орхон Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Увс аймагт хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг зохион байгуулаагүй байна.

Хөтөлбөр хэрэгжүүлснээр сурагчдын эрүүл мэндэд эерэг өөрчлөлт гарсан эсэхийг тооцох боломжгүй байна

3.27 Журмын дагуу улирал бүр сурагчдын жин, өндрийг хэмжиж үнэлгээ, дүгнэлт өгөх заалттай хэдий ч сургууль бүр дээрх үзүүлэлтийг хэмжих багаж төхөөрөмжөөр хангагдаагүй, зарим сургуульд хүүхдийн тооноос шалтгаалан бүрэн хэмжээгээр хамруулж чаддаггүй, хэмжилт хийсэн боловч үнэлгээ дүгнэлт хийгдээгүй байдал түгээмэл байна.



3.28 Үдийн цайнд өгч буй хүнсний бүтээгдэхүүн хүүхдийн биед сөрөг нөлөө үзүүлдэг эсэх талаархи асуулгад сурагчдын 87 хувь, багшийн 76 хувь, эцэг эхийн 79 хувь “Үгүй” гэж хариулсан. Санал асуулгад оролцогчдын гуравны нэг хувь нь сөрөг нөлөө үзүүлж байсан гэж хариулснаас үзэхэд эрүүл ахуйн шаардлага хангахааргүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байсан гэдгийг үгүйсгэхгүй байна.

3.29 “Хүүхдүүд сургууль дээр үдийн цайнд хамрагдах болсноор эерэг өөрчлөлт гарч байна уу” гэсэн асуулгад нийт багшийн 87 хувь, эцэг эхийн 78 хувь “Тийм” буюу дийлэнх хэсэг нь хөтөлбөр хэрэгжсэнээр эерэг өөрчлөлт гарч чадсан гэж үзэж байна.

3.30 Аудитын явцад бага ангийн багш, сургуулийн эмч нартай ярилцахад сурагчдад үдийн цайг өгснөөр хотын захын болон хөдөө орон нутгийн сургуулиудад амьдрал ядуу, орлого багатай айл өрхийн хүүхдийн хичээлд оролцох идэвх нэмэгдэж, хичээл таслалт багасах эерэг нөлөө гарч байгаа талаар дурдаж байлаа.

Зөвлөмж: БСШУ-ны сайд Н.Болормаад:

- ЭМЯ-тай хамтран хүүхдийн насны онцлогт тохирсон Үдийн цайны стандарт гаргах асуудлыг судалж, шийдвэрлэх,
- Төв, суурин газрын сургуулиудад үдийн цайны хүнсний бүтээгдэхүүнийг төвлөрсөн журмаар бэлтгэн нийлүүлж үйлчлэх боломжийг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- “Үдийн цай” хөтөлбөрт хамруулах суралцагчдыг ар гэрийн амьжиргааны түвшинтэй нь уялдуулах боломжийг судалж санал боловсруулах.

Холбогдох байгууллагын санал

Сангийн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2008.06.23 № 5-74/3391
танай _____ -ны № 234 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тусгайлан өгөх саналгүй болно.

Харин зөвлөмжийг биелүүлэх болон илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг арилгах талаар ажлын төлөвлөгөө боловсруулж зохих арга хэмжээг авч ажиллана.



Д.Баттөр Д.БАТТӨР

08 2112

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн санал:



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 32-31-58
E-mail: mecs@mecs.pmis.gov.mn
Web address: http://mecs.pmis.gov.mn/

2008.06.23 № 2/3528
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Л.ЖАВЗМАА ТАНАА

Санал өгөх тухай

Үндэсний аудитын газраас ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.

Нэг. “Үдийн цай хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилтийн талаар:

Боловсролын салбарын хувьд хичээлийн жил нь санхүүгийн жилтэй зөрдөгөөс шалтгаалан дараа оны төсвийн төлөвлөхдөө суурин хүн амын тоо болон өмнөх хичээлийн жилийн хүүхдийн тоонд үндэслэн 2 хичээлийн жилийн хүүхдийн тоог прогнолох хэрэгтэй болдог. Тухайлбал 2006 оны 7 сард төсвийн төсөл боловсруулахад 2007 онд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог төлөвлөхдөө:

2005-2006 оны хичээлийн жилийн хүүхдийн тоо	} Суурин хүн + амын тооноос шинээр элсэх хүүхдийн тоо
+ 2006-2007 оны хичээлийн жилийн хүүхдийн тооны өөрчлөлт	
+ 2007-2008 оны хичээлийн жилийн хүүхдийн тооны өөрчлөлтийг прогнолодог.	

Дээрхээс үзэхэд хүүхдийн тоог төлөвлөхөд суурин хүн амын тооны Монгол Улсын статистик мэдээний найдвартай байдал, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг манай салбараас шалтгаалахгүй олон хүчин зүйл нөлөөлж байгаа юм. Тухайлбал, суурин хүн амын тоонд шилжилт хөдөлгөөнийг тусгадаггүй байна.

Үдийн цай хөтөлбөрт хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлангийн 1.3-д Баян-өлгий, Булган, Сэлэнгэ, Ховд, Сүхбаатар, Төв аймагт хүүхдийн тоо илүү төлөвлөгдсөн байна гэсэн дүгнэлтийг хийжээ. Хүүхдийн тоог илүү төлөвлөгдөж төсөв илүү хуваарилагдсан байсан ч санхүүжилтийг хүүхэд-өдрийн гүйцэтгэлээр хийдэг, хүүхэд-өдрийн төлөвлөгөө биелэхгүй байх нь хүүхдийн тоог илүү төлөвлөсөн гэсэн үг биш юм. Энэ нь тухайн сургалтын байгууллага нь нийлүүлэхээр гэрээлсэн бүтээгдэхүүнээ бүрэн нийлүүлээгүй гэсэн үг юм. Иймд Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсвийн хэмнэлт, хэтрэлийг тооцох журмаар хүүхдийн тоотой холбоотой буюу өөрөөр хэлбэл хүүхэд-өдрийн төлөвлөгөө биелээгүйгээс хэмнэгдсэн төсвийг хэмнэлтэд тооцохгүй бөгөөд улсын төсөвт буцаан төвлөрүүлэх ёстой юм.

Төлөвлөлтийг урьдчилан таамаглаж байгаа тоо мэдээнд үндэслэн хийдэг тул гүйцэтгэлтэй яг таарч байх боломжгүй, харин хамгийн сайн төлөвлөлт гүйцэтгэлтэй хамгийн их ойролцоо зохицуулалт хийх боломжтой, уян хатан байх ёстой гэж үздэг. “Үдийн цай” хөтөлбөрт хийсэн гүйцэтгэлийн тайлангаар илүү төлөвлөсөн гэж дүгнэсэн

1008385

501.3 сая төгрөгийн 58.8 сая төгрөгийг нь л манай салбар буруу төлөвлөсөн гэж ойлголоо. Энэ нь тус тайлангийн эцсийн дүгнэлт болох "...2007 онд олгох санхүүжилтийг 7.8 хувийн алдаатай төлөвлөжээ" гэсний 0.9 хувь нь манай яамны Санхүү, эдийн засгийн газрын төлөвлөлтийн алдаа байх тул тус газар үдийн цайны төсвийг бодитой төлөвлөж байна гэж үзэж болохоор байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам 9.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн төсөв Улсын Их Хурлаар 10.0 тэрбум болон нэмэгдэж ирсэн тул бид батлагдсан төсвийг хуваарилсан. Харин салбарын санхүүгийн тайлангаар орон нутгийн төрийн сан дээр 47.4 сая төгрөг, сургууль дээр 386.2 сая төгрөг үлдсэн бөгөөд сургуулиуд Үдийн цайнд нийт 9.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Санхүүгийн тайланд зардлыг үнэн зөв тусгаж байгаа эсэхийг салбарын тайланг нэгтгэн хүлээн авах үед тогтоох боломжгүй байдаг бөгөөд тайлангийн нэгтгэлийг аудитаар баталгаажуулсан байхыг шаарддаг. Иймд санхүүгийн тайлан буруу гарч байгаа нь аудитын чанартай ямар нэг хэмжээгээр холбоотой гэж үзэж байна.

Хоёр. Бэлтгэн нийлүүлэгчийг хуулийн дагуу сонгоогүй талаар:

1. Энэхүү гэрээг байгуулахдаа гэрээний хугацааг журамд тусгайлан зааж өгсөн. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд нийлүүлэх бүтээгдэхүүний өртөгтэй дүйцэх хэмжээний санхүүжилтийн хөрөнгөд тохируулан гэрээ хийгдэх тул дээрх хуульд заасны дагуу зохион байгуулах боломжгүй гэж үзсэн. Сургууль гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүний чанар байдалд тогтмол хяналт тавих боломжийг хангах үүднээс гэрээг 2-3 сараар /улирал тутмаар/ хийж байхаар заасан. Журмын 4.3-д үдийн цайны цэс зохиоход нэг өдрийн үдийн цай 300 төгрөгт багтсан байх шаардлагыг тавьдаг. Эндээс үзэхэд тухайн аж ахуйн нэгжтэй хийх гэрээг 3 сараар хийхэд 1 сарыг 22 өдрөөр тооцож үзэхэд нийт 1 сард 6600 төгрөг, 3 сард 19800 төгрөг нь болох бөгөөд үүнийг сурагчдын тоогоор тооцсноор, 1 улиралд хийгдэх гэрээний үнийн дүн 20.000 000 төгрөг болж байна. Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ батлах тухай Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолын хавсралтад зааснаар харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа-30 сая төгрөг, ажил 50 сая төгрөг байна. Энэ өртөгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер зарлах боломжгүй юм. Хуулийн дагуу төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад тендер зарлаж гүйцэтгэчийг сонгохдоо гүйцэтгэгч компанид тодорхой хэмжээний ашигтай байхаар өртгийг тооцоолдог. Харин үүнийг батлагдсан хөтөлбөрийн дагуу явагдаж буй төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа тул ашиг, алдагдлыг тооцож, улмаар тендерийг үнэлэх тусгай шаардлага, техникийн тодорхойлолтыг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг бичиг баримтын дагуу боловсруулж, мөн хуульд заасан тухайлсан хугацаа бүрээр гүйцэтгэгч сонгох амьдралд зүйд нийцэхгүй байна.

Гурав: Бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарт тавих эцэг эхчүүдийн хяналт хангалтгүй, сургуульд эмч ажиллуулах гэсэн талаар:

Аудитын дүгнэлтээс үзэхэд сурагчдын 91 хувь, багш нарын 87 хувь, эцэг эхийн 78 хувь нь үдийн цайнд өгч буй бүтээгдэхүүн таалагддаг гэж хариулсан нь хөтөлбөрийн үр дүнг харуулах үзүүлэлт юм. Үүнийг үндэслээд "Үдийн цай" хөтөлбөр ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж үзэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн нийгмийн хамгааллын асуудал болон ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 280/131 дүгээр хамтарсан тушаалаар байгуулж ажлын хэсэг ажиллаж байна. Цаашид сургууль цэцэрлэгийг эмчтэй болгох замаар энэ асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. 2007-

2008 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд 279 эмч буюу нийт сургуулийн 37.0 хувьд нь эмч ажиллаж байна.

Тус яамны МХШҮГ-аас 2006-2007 оны хичээлийн жилд үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, зөвлөмж гарган бүх сургуулиудад хүргэн ажиллаж байна. Үүний зэрэгцээ Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар 2007 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд мэдээлэл бэлтгэн танилцуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гаргасан билээ.

Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд бүтээгдэхүүний чанарын шаардлага хангаж буй эсэхэд УМХГ-ын байцаагчийн дүгнэлт бүхий хүнсний бүтээгдэхүүн байхаар журамд заасан байгаа. Цаашид эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан орчинд, бүтээгдэхүүнд тавих мэргэжлийн байгууллагын хяналтыг нэмэгдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа чухал байгаа учраас зөвлөмжид зөвхөн БСШУЯ-д төдийгүй Үйлдвэр Худалдааны яам, Улсын Мэргэжлийн Хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам зэрэг газруудад тодорхой зөвлөмжийг өгвөл ач холбогдолтой болно гэж үзэж байна.

"Үдийн цай" хөтөлбөрт аудит хийж мэргэжлийн үнэлгээ өгсөн нь энэ хөтөлбөрийг цаашид илүү үр дүнтэй, бодитой туслалцаа дэмжлэг боллоо.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.МИШИГЖАВ

Нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газраас ирүүлсэн санал:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗАР

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 10а, Утас/Факс: 32-49-47

2008.06.17 № 1/255
танай 2008.06.16 -ны № 234 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Ерөнхий боловсролын бага ангийн хүүхдүүдийн
"Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн Аудитын
дүгнэлттэй танилцлаа.

Цаашид Нийслэлийн ерөнхий боловсролын
сургуулиудад илэрсэн зөрчил дутагдлыг засах, давтан
гаргахгүй байх талаар анхаарч ажиллах болно.



ДАРГА

Д.ЭНХБАЯР

C:\blank\shine jijig-1\08doc

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

БСШУЯ-ны 2008 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн “Санал өгөх тухай” 2/3527 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг судалж үзэхэд тухайн асуудлууд нь аудитын тайланд дэлгэрэнгүй тусгагдсан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Хавсралтууд

Хавсралт №1

Монгол Улсын хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 2007 онд ЕБС-ын 1.4 ангийн хүүхдүүдэд "Үдийн цай" хөтөлбөрөөр олгосон санхүүжилт

Д.д	Аудитад хамрагдсан аймаг, дүүрэг, сургууль	Жилийн батлагдсан төлөвлөгөө	Олгосон санхүүжилт		Гүйцэтгэлээр		Зарцуулагдаагүй үлдэгдэл		Үлдэгдлийг буцааж төвлөрүүлсэн эсэх	Олгосон санхүүжилт /СЯ/	Зөрүү
			Сургууль	Дүн	Сургууль	Дүн	Сургууль	Дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Архангай	414,854.5	37	400,285.6	37	369,631.4	27	30,654.2	-	414,854.5	14,568.9
2	Баян-Өлгий	452,775.8	37	440,898.3	37	426,928.0	10	25,847.8	-	452,775.8	11,877.5
3	Баянхонгор	379,670.4	28	379,670.4	28	367,531.4	13	12,138.9	-	379,670.4	-
4	Булган	206,396.9	24	199,594.3	24	172,944.4	24	26,649.9	21,001.9	206,396.9	6,802.6
5	Говь-Алтай	276,957.1	30	276,957.1	30	245,561.6	22	31,464.7	1,423.3	276,957.1	-
6	Говьсүмбэр	61,057.8	4	61,057.8	4	51,647.6	4	9,410.2	7,858.1	61,057.8	-
7	Дархан-Уул	364,658.0	23	358,388.3	23	355,830.9	6	8,365.4	-	364,658.0	6,269.7
8	Дорнод	283,235.2	25	283,235.2	25	269,896.6	17	13,338.6	-	283,235.2	-
9	Дорноговь	212,483.8	22	212,483.8	22	193,514.5	8	14,640.9	4,328.4	212,483.8	-
10	Дундговь	198,052.8	19	175,769.7	19	168,174.1	13	7,595.6	-	198,052.8	22,283.1
11	Завхан	330,202.8	31	318,105.5	31	300,443.8	31	17,990.2	-	330,202.8	12,097.3
12	Орхон	316,583.5	13	309,140.5	13	294,430.0	8	14,710.5	-	316,583.5	7,443.0
13	Өвөрхангай	484,801.3	28	484,801.3	28	439,067.0	28	16,060.7	-	484,801.3	-
14	Өмнөговь	210,361.5	18	210,361.5	18	190,358.1	9	1,434.5	20,664.8	210,361.5	-
15	Сүхбаатар	235,635.4	14	235,635.4	14	219,129.4	11	16,506.0	-	235,635.4	-
16	Сэлэнгэ	374,179.7	33	337,759.9	33	326,365.7	13	11,394.2	-	374,179.7	36,419.8
17	Увс	424,395.8	27	411,528.5	27	394,512.9	16	17,015.6	-	424,395.8	12,867.3
18	Төв	284,978.0	37	279,887.2	37	244,227.8	28	35,659.4	-	284,978.0	5,090.8
19	Ховд	451,115.1	24	408,254.6	24	387,481.0	10	24,331.7	42,861.0	451,115.1	42,860.5
20	Хөвсгөл	513,022.1	30	513,022.1	30	456,147.6	24	56,874.5	11,320.5	513,022.1	-
21	Хэнтий	287,319.5	27	287,319.5	27	278,825.3	11	8,494.2	-	287,319.5	-
	Аймгийн дүн	6,762,737.0	531	6,584,156.5	531	6,152,649.1	333	400,577.7	109,458.0	6,762,737.0	178,580.5
22	БГДүүрэг	307,542.8	11	307,542.7	11	307,542.7	-	-	-	307,542.7	-
23	БЗДүүрэг	478,497.3	16	474,835.4	16	448,456.1	13	26,379.3	-	474,835.4	-
24	СХДүүрэг	597,714.9	13	551,884.4	13	526,137.7	10	25,746.7	-	597,714.9	45,830.5
25	ХУДүүрэг	238,893.6	12	238,893.6	12	226,869.1	11	12,024.5	-	238,893.6	-
26	Сүхбаатар	292,392.6	12	290,910.0	12	286,009.0	6	4,901.0	-	290,910.0	-
27	Чингэлтэй	332,020.0	11	332,020.0	11	312,809.8	11	19,210.2	-	332,020.0	-
28	Баянзүр	92,554.8	1	92,554.8	1	87,883.9	1	4,670.9	-	92,554.8	-
29	Багахангай	9,400.8	1	9,400.8	1	6,650.9	1	2,749.9	-	9,400.8	-
30	Налайх	90,903.0	2	90,903.0	2	85,808.5	2	5,094.5	-	90,903.0	-
	Нийтлэлийн дүн	2,439,919.8	79	2,388,944.7	79	2,288,167.7	55	100,777.0	109,458.0	2,434,775.2	45,830.5
	Бүгд	9,202,656.8	610	8,973,101.2	610	8,440,816.8	388	501,554.7	109,458.0	9,197,512.2	224,411.0

/мян.төг/

Ерөнхий боловсролын сургуулийн 1-4 дүгээр ангийн хүүхдүүдэд олгох
"Удийн цай" хөтөлбөрийн санхүүгийн тооцоолол /2007 оны санхүүгийн жилээр/

Д.д	Аудитад хамрагдсан аймаг, дүүрэг, сургууль	2006-2007 оны хичээлийн жил (хоёрдугаар хагас жил буюу 2007.01.01-2007.05.01)					2007-2008 оны хичээлийн жил (эхний хагас жил буюу 2007.09.01-2007.12.31)				2006-2007 оны хичээлийн жилийн нийт хүүхэд/өдөр	Дундаж хүүхдийн тоо (санхүүгийн жилээр/	Тооцолсон нийт зардал
		I анги	II анги	III анги	IV анги	I анги	II анги	III анги	IV анги				
		3	4	5	6	7	8	9	10				
1	Архангай	2,247	2,221	1,201	1,779	2,529	2,126	2,217	1,116	1,309,900	7,705	392,970.0	
2	Баян-Өлгий	2,696	2,675	574	2,665	3,017	2,542	2,588	704	1,483,221	8,725	444,966.3	
3	Баянхонгор	2,068	2,098	1,307	1,238	2,288	2,041	2,137	1,319	1,227,864	7,223	368,359.2	
4	Булган	1,098	943	570	1,199	1,090	951	727	795	627,693	3,692	188,307.9	
5	Говь-Алтай	1,459	1,410	937	1,213	1,406	1,396	1,350	895	855,498	5,032	256,649.4	
6	Говьсүмбэр	309	306	97	239	302	305	306	99	166,611	980	49,983.3	
7	Дархан-Уул	2,161	1,893	1,457	1,314	2,148	2,105	1,630	1,286	1,188,114	6,989	356,434.2	
8	Дорнод	1,564	1,480	1,074	798	1,791	1,428	1,405	1,028	895,336	5,267	268,600.8	
9	Дорноговь	1,216	1,008	503	1,081	1,332	1,238	1,116	688	693,206	4,078	207,961.8	
10	Дундговь	1,028	999	641	911	1,051	1,004	954	599	610,779	3,593	183,233.7	
11	Завхан	1,789	1,755	1,120	1,287	1,957	1,774	1,733	1,088	1,060,351	6,237	318,105.3	
12	Орхон	1,902	1,536	551	1,892	1,734	1,846	1,422	706	985,757	5,799	295,727.1	
13	Өвөрхангай	2,646	2,514	1,420	1,863	2,788	2,529	2,432	1,485	1,499,381	8,820	449,814.3	
14	Өмнөговь	1,020	992	778	800	1,444	1,004	1,033	790	665,461	3,914	199,638.3	
15	Сүхбаатар	1,198	1,237	867	852	1,212	1,162	1,089	836	717,925	4,223	215,377.5	
16	Сэлэнгэ	2,267	1,968	958	1,447	2,058	2,220	1,926	977	1,172,621	6,898	351,786.3	
17	Увс	2,329	2,265	1,225	2,134	2,280	2,139	2,155	1,210	1,338,321	7,872	401,496.3	
18	Төв	1,575	1,588	945	934	1,714	1,510	1,489	662	884,113	5,201	265,233.9	
19	Хөвд	2,301	2,341	1,247	1,965	2,575	2,137	2,322	1,264	1,371,144	8,066	411,343.2	
20	Хөвсгөл	2,989	2,838	1,738	2,314	3,311	2,729	2,620	1,618	1,711,749	10,069	513,524.7	
21	Хэнтий	1,737	1,385	1,049	1,055	1,771	1,537	1,373	1,055	929,730	5,469	278,919.0	
	Аймгийн дүн	37,599	35,452	20,259	28,980	39,798	35,723	34,024	20,220	21,394,775	125,852	6,418,432.5	
22	БГДүрэг	1,933	1,790	572	1,900	2,012	1,917	1,870	598	1,069,512	6,291	320,853.6	
23	БЗДүрэг	2,885	2,593	1,119	2,525	2,886	2,741	2,355	1,217	1,556,977	9,159	467,093.1	
24	СХДүрэг	3,414	3,264	1,599	2,429	3,865	3,516	3,072	1,511	1,921,918	11,305	576,575.4	
25	ХУДүрэг	1,493	1,404	429	1,402	1,475	1,439	1,348	428	800,682	4,710	240,204.6	
26	Сүхбаатар	1,849	1,668	719	1,288	1,834	1,714	1,456	678	951,878	5,599	285,563.4	
27	Чингэлтэй	2,246	2,314	1,114	2,050	2,393	2,426	2,367	1,144	1,362,166	8,013	408,649.8	
28	Баянхур	490	530	280	412	571	488	519	281	302,947	1,782	90,884.1	
29	Багахангай	60	62	10	49	61	63	53	47	34,253	201	10,275.9	
30	Налайх	616	504	210	462	554	511	470	179	298,322	1,755	89,496.6	
	Нийслэлийн дүн	14,986	14,129	6,052	12,517	15,951	14,815	13,510	6,083	8,298,655	48,816	2,489,596.5	
	Бүгд	52,585	49,581	26,311	41,497	55,449	50,538	47,534	26,303	29,693,430	174,667	8,908,029	

2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн 1-2 дугаар ангийн хүүхдүүдэд
олгох үдийн цайны санхүүгийн тооцоолол /9-12 сар/

Д.Д	Аудитад хамрагдсан аймаг, дүүрэг, сургууль	2006-2007 оны хичээлийн жил		2006-2007 оны хичээлийн жилийн нийт хүүхэд/өдөр	Дундаж хүүхдийн тоо /санхүүгийн хилээр/	Тооцолсон нийт зардал	Гүйцэтгэл		Зөрүү		Олгосон санхүүжилт	Зөрүү
		I анги	II анги				хэтрэлт	хэмнэлт	хэтрэлт	хэмнэлт		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Архангай	2,261	2,316	372,516	4,597	111,755.7	109,320.7		2,435.0	111,755.7	2,435.0	
2	Баян-Өлгий	2,750	2,883	440,073	5,433	131,856.6	117,845.4		13,811.2	131,317.2	13,471.8	
3	Баянхонгор	2,050	2,118	337,448	4,166	101,233.8	96,670.0		322.9	102,181.5	5,511.5	
4	Булган	1,110	962	167,832	2,072	50,359.7	44,854.5		328.9	50,349.6	5,495.1	
5	Говь-Алтай	1,459	1,410	232,389	2,869	69,716.7	69,838.1		121.4	69,838.1	-	
6	Говьсүмбэр	309	306	49,815	615	14,944.5	14,964.4		19.9	14,944.5	(19.9)	
7	Дархан-Уул	2,236	1,942	339,366	4,177	98,998.2	95,267.2		9.1	3,740.1	98,998.2	
8	Дорнод	1,564	1,480	246,564	3,044	73,969.2	73,969.2		-	73,969.2	-	
9	Дорноговь	1,216	1,008	180,144	2,224	54,043.2	52,609.5		47.7	1,481.4	54,990.9	
10	Дундговь	1,029	999	164,268	2,028	49,280.4	45,286.6		367.8	4,361.6	49,280.4	
11	Завхан	1,792	1,753	287,145	3,545	86,143.5	86,143.5		1,351.2	994.1	86,143.5	
12	Орхон	1,904	1,504	276,048	3,408	82,814.4	83,171.5		994.1	83,786.4	614.9	
13	Өвөрхангай	2,617	2,510	415,287	5,127	124,586.1	122,385.8		2,200.3	127,210.5	4,824.7	
14	Өмнөговь	1,041	1,069	170,910	2,110	51,273.0	48,313.3			2,959.7	51,248.7	
15	Сүхбаатар	1,198	1,237	197,235	2,435	59,170.5	60,069.6		3,812.4	2,913.3	60,069.6	
16	Сэлэнгэ	2,115	2,056	337,851	4,171	94,794.3	94,794.3			102,910.5	8,116.2	
17	Увс	2,329	2,265	372,114	4,594	111,634.2	111,634.2			111,099.6	(534.6)	
18	Төв	1,644	1,702	271,026	3,346	81,307.8	77,413.7		901.7	4,795.7	79,801.4	
19	Ховд	2,301	2,341	376,002	4,642	112,800.6	108,007.0		11.6	4,805.2	112,800.6	
20	Хөвсгөл	2,819	2,791	454,410	5,610	139,572.6	130,496.6		2,455.9	10,532.9	137,610.9	
21	Хэнтий	1,608	1,385	242,433	2,993	72,729.9	72,729.9		1,315.3	2,574.6	72,729.9	
	Аймгийн дүн	37,352	35,837	5,929,876	73,206	1,771,784.9	1,715,785.0		11,065.8	68,325.9	1,783,036.9	67,251.9
22	БГДүрэг	1,555	1,444	242,919	2,999	72,875.7	71,616.4		1,315.3	2,574.6	71,616.4	
23	БЗДүрэг	2,939	2,658	453,357	5,597	136,007.1	130,041.2		275.0	6,241.0	130,041.2	
24	СХДүрэг	3,554	3,247	550,881	6,801	165,264.3	166,860.3		6,109.5	2,513.5	171,500.8	
25	ХУДүрэг	1,493	1,404	234,657	2,897	70,397.1	68,994.0		201.0	1,603.0	70,397.1	
26	Сүхбаатар	1,964	1,776	302,940	3,740	90,882.0	89,778.4		1,103.6	89,778.4	-	
27	Чингэлтэй	1,810	1,638	279,288	3,448	83,786.4	85,001.0		1,805.0	590.4	85,001.0	
28	Баянзүр	490	530	82,620	1,020	24,786.0	24,786.0			24,786.0	-	
29	Багахангай	61	55	9,396	116	2,818.8	2,818.8			2,818.8	-	
30	Налайх	616	504	90,720	1,120	27,216.0	27,216.0			27,216.0	-	
	Нийслэлийн дүн	14,482	13,256	2,246,778	27,738	674,033.4	667,112.1		9,705.8	14,626.1	673,155.7	6,043.6
	Бүгд	51,834	49,093	8,176,654	100,944	2,445,818	2,382,897		20,772	82,952	2,456,193	73,296

/млн.төг/

**Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн гүйцэтгэлийн аудитаар
илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт**

/млн.төг/

Д.д	Аудитад хамрагдсан аймаг, дүүрэг, сургууль	Сургуулийн тоо	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр	Зөрчил	Дүн	Аудитын явцад барагдуулсан	
							ҮАГ	МУХСан
1	2	3	4	5	6	7	8	9
1	Архангай	16	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	26,872.9	19,255.1	46,128.0		
2	Баян-Өлгий	1	Зориулалт бус	98.1	25,100.0	25,198.1		
3	Баянхонгор	4	Зориулалт бус	1,400.0	2,558.6	3,958.6		3,452.8
4	Булган	12	Зориулалт бус	17,501.2		17,501.2		27,098.6
5	Говь-Алтай	22	Зориулалт бус	29,941.4		29,941.4		32,103.2
6	Говьсүмбэр	4	Зориулалт бус	428.9	1,668.3	2,097.2		8,693.3
7	Дархан-Уул	21	Зориулалт бус	41,120.3	798.8	41,919.1		6,269.6
8	Дорнод	17	Үлдэгдэл төвлөрүүлэх	13,338.6		13,338.6		
9	Дорноговь	5	Үлдэгдэл төвлөрүүлэх		11,980.5	11,980.5		9,603.8
10	Дундговь	16	Зориулалт бус	35,869.6		35,869.6		22,283.1
11	Завхан	18	Үлдэгдэл төвлөрүүлэх	17,990.2		17,990.2		
12	Орхон	11	Илүү санхүүжилт	1,820.9	15,740.2	17,561.1		817.8
13	Өвөрхангай	14	Зориулалт бус	12,900.3	37,004.4	49,904.7		
14	Өмнөговь	17	Зориулалт бус	2,742.3		2,742.3		161.3
15	Сүхбаатар	10	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	16,506.0		16,506.0		
16	Сэлэнгэ	14	Бараа авсан	6,616.4	4,003.8	10,620.2		4,398.3
17	Төв	50	Зориулалт бус	22,239.3	22,293.5	44,532.8		360.3
18	Увс	17	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	19,352.1		19,352.1		4,489.0
19	Ховд	17	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	6,657.2	17,674.5	24,331.7		
20	Хөвсгөл	30	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	43,026.5	13,848.0	56,874.5		43,026.4
21	Хэнтий	8	Зарцуулагдаагүй үлдэгдэл, зориулалт бус зарцуулалт	20,144.7		20,144.7		
	ДҮН	324		336,566.9	171,925.7	508,492.6	-	162,757.5
22	Чингэлтэй дүүрэг	11	Зарцуулагдаагүй үлдэгдэл	20,872.7		20,872.7		20,872.7
23	Хан-Уул дүүрэг	12	Зарцуулагдаагүй үлдэгдэл	12,221.0		12,221.0		12,221.0
24	Сүхбаатар дүүрэг	6	Зарцуулагдаагүй үлдэгдэл	5,681.7		5,681.7	3,491.0	2,190.7
25	СХДүүрэг	11	Зарцуулагдаагүй үлдэгдэл	36,968.0		36,968.0	4,058.2	32,909.8
26	БЗДүүрэг	13	Зарцуулагдаагүй үлдэгдэл	34,945.0		34,945.0	2,819.3	32,125.7
27	Налайх дүүрэг	1	Зарцуулагдаагүй үлдэгдэл	895.1		895.1		895.1
28	Багахангай дүүрэг	1	Зарцуулагдаагүй үлдэгдэл	2,749.9		2,749.9		2,749.9
29	Багануур дүүрэг	1	Зарцуулагдаагүй үлдэгдэл	5,126.7		5,126.7		5,126.7
	ДҮН	56		119,460.1	-	119,460.1	10,368.5	109,091.6
	БҮГД ДҮН	380		456,027.0	171,925.7	627,952.7	10,368.5	271,849.1

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авсан асуулгын нэгтгэл

Д.д	Асуулт	Хариултын тоо		Дүн	Хариултын хувь	
		Тийм	Үгүй		Тийм	Үгүй
1	Үдийн цайгаар өгч байгаа бүтээгдэхүүн чамд таалагддаг уу?	36152	3653	39805	90.8	9.2
	Хүнсний бүтээгдэхүүнийг идсэний дараа бие чинь өвдсөн тохиолдол бий юу? (бие өвдөх, гэдэс базлах, гүйлгэх г.м)	5195	34013	39208	13.2	86.8
3	Бүтээгдэхүүний чанар сайн байсан уу?	33178	6037	39215	84.6	15.4
4	Нэг төрлийн бүтээгдэхүүнийг олон удаа өгдөг үү? (сард хэдэн удаа өгдөг вэ?)	16191	22268	38459	42.1	57.9
5	Үдийн цайнд өгч байгаа бүтээгдэхүүн хэмжээний хувьд болж байна уу?	33529	5078	38607	86.8	13.2
6	Бүтээгдэхүүний амт сайн байна уу?	33355	5114	38469	86.7	13.3
7	Бүтээгдэхүүн сав баглаа боодолтой ирдэг үү?	34419	4447	38866	88.6	11.4
8	Үдийн цайны өмнө чи гараа тогтмол угаадаг уу?	30998		30998	78.8	21.2
9	Хооллох анги танхим эрүүл ахуйн нөхцөлийг хангаж байна уу?	31248	7860	39108	79.9	20.1
10	Үдийн цайгаа хаана уудаг вэ?					
	а/ Ангид	29378	2301	31679	92.7	7.3
	б/ Сургуулийн хоолны газар	2987	1469	4456	67.0	33.0
11	Үдийн цайг тогтмол хугацаандаа иддэг үү?	32934	2041	34975	94.2	5.8
12	Та бүхний санал хүсэлтийг харгалзан үздэг үү?	19507	10541	30048	64.9	35.1

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эхээс авсан асуулгын нэгтгэл

Д.д	Асуулт	Хариултын тоо		Дүн	Хариултын хувь	
		Тийм	Үгүй		Тийм	Үгүй
1	Та хүүхэдтэйгээ хөтөлбөрийн талаар ярилцдаг бол "Тийм" гэж дараах асуултад хариулна уу?	5711	721	6432	88.8	11.2
2	Үдийн цайгаар танай хүүхдэд өгч байгаа бүтээгдэхүүн танд таалагдаж байна уу?	5207	1476	6683	77.9	22.1
3	Хүнсний бүтээгдэхүүнийг идэж, ууж хэрэглэснээс хойш танай хүүхдийн биед сөрөг нөлөө үзүүлсэн үү? (бие өвдөх, гэдэс базлах, гүйлгэх г.м)	1450	5386	6836	21.2	78.8
4	Бүтээгдэхүүний чанар сайн байсан гэдэгт та санал нийлэх үү?	4913	1807	6720	73.1	26.9
5	Нэг төрлийн бүтээгдэхүүнийг олон удаа өгдөг үү?	3213	3303	6516	49.3	50.7
6	Үдийн цайнд өгч байгаа бүтээгдэхүүн хэмжээний хувьд болж байна уу?	5483	1413	6896	79.5	20.5
7	Бүтээгдэхүүний амт сайн байна уу?	5413	1435	6848	79.0	21.0
8	Бүтээгдэхүүн сав баглаа боодолтой ирдэг үү?	5145	1707	6852	75.1	24.9
9	Сурагч бүрийг гарыг нь угаалгаж байна уу?	5275	1532	6807	77.5	22.5
10	Хооллох анги танхим эрүүл ахуйн нөхцөлийг хангаж байна уу?	5110	1738	6848	74.6	25.4
11	Үдийн цайг тогтмол цаг хугацаанд өгч байна уу?	6240	1042	7282	85.7	14.3
12	Нийлүүлж байгаа бүтээгдэхүүний талаар танд санал гомдол байна уу?	2054	4763	6817	30.1	69.9
13	Үдийн цайгаар олгож байгаа бүтээгдэхүүн болон үйл явцад эцэг эхийн зүгээс хяналт тавьдаг уу?	4519	2330	6849	66.0	34.0
14	Таны хүүхэд үдийн цайгаа сургууль дээр уух болсноор ямар үр дүн, өөрчлөлт гарч байна вэ?(сурлагын ахиц, биений хөгжил, өөрчлөлт, эрүүл мэндийн байдал гэх мэт зэрэг өөрчлөлт)	4915	1348	6263	78.5	21.5
15	Үдийн цайны үйлчилгээний талаар сургуулийн захиргаанаас сурагчдын эцэг, эх нарт танилцуулж байна уу? (улиралд 1 удаа танилцуулах ёстой)	4147	2636	6783	61.1	38.9
16	Нэг хүүхдэд ногдох мөнгөний хэмжээ хүрэлцэж байна уу?	4665	2190	6855	68.1	31.9

Ерөнхий боловсролын сургуулийн багш нараас авсан асуулгын нэгтгэл

Д.д	Асуулт	Хариултын тоо		Дүн	Хариултын хувь	
		Тийм	Үгүй		Тийм	Үгүй
1	Үдийн цайгаар хүүхдэд өгч байгаа бүтээгдэхүүн танд таалагдаж байна уу?	2,865	432	3,297	86.9	13.1
2	Хүнсний бүтээгдэхүүнийг идэж, ууж хэрэглэснээс хойш хүүхдийн биед сөрөг нөлөө үзүүлсэн үү? (бие өвдөх, гэдэс базлах, гүйлгэх г.м)	786	2,492	3,278	24.0	76.0
3	Бүтээгдэхүүний чанар сайн байсан гэдэгт та санал нийлэх үү?	2,370	967	3,337	71.0	29.0
4	Нэг төрлийн бүтээгдэхүүнийг олон удаа өгдөг үү?	1,414	1,903	3,317	42.6	57.4
5	Үдийн цайнд өгч байгаа бүтээгдэхүүн хэмжээний хувьд болж байна уу?	2,473	841	3,314	74.6	25.4
6	Бүтээгдэхүүний амт сайн байна уу?	2,632	680	3,312	79.5	20.5
7	Бүтээгдэхүүн сав баглаа боодолтой ирдэг үү?	2,648	647	3,295	80.4	19.6
8	Сурагч бүрийг гарыг нь угаалгах боломж байна уу?	2,044	1,263	3,307	61.8	38.2
9	Хооллох анги танхим эрүүл ахуйн нөхцөлийг хангаж байна уу?	2,156	1,139	3,295	65.4	34.6
10	Үдийн цайг тогтмол цаг хугацаанд өгч байна уу?	2,855	473	3,328	85.8	14.2
11	Та үдийн цайнд нийлүүлж буй хүнсний бүтээгдэхүүний талаар санал нийлж байна уу?	1,280	1,957	3,237	39.5	60.5
12	Үдийн цайгаар олгож байгаа бүтээгдэхүүн болон үйл явцад сургуулийн захиргаа, эцэг эхийн зүгээс хяналт тавьдаг уу?	2,587	674	3,261	79.3	20.7
13	Үдийн цайгаа сургууль дээр уух болсноор үр дүн, өөрчлөлт гарч байна уу? (сурлагын ахиц, биеийн хөгжил, эрүүл мэндийн байдал гэх мэт эерэг өөрчлөлт)	2,696	420	3,116	86.5	13.5
14	Үдийн цайны үйлчилгээний талаар сургуулийн захиргаанаас сурагчдын эцэг, эх нарт танилцуулж байна уу? (улиралд 1 удаа танилцуулах ёстой)	2,282	969	3,251	70.2	29.8
15	Нэг хүүхдэд ногдох мөнгөний хэмжээ хүрэлцэж байна уу?	2,149	1,041	3,190	67.4	32.6
16	Эцэг, эхийн саналыг авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн үү?	1,945	1,038	2,983	65.2	34.8



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлсүгэй.

Гурав.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч дүнг 2008 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад зөвлөсүгэй.

Дөрөв.Аудитын явцад тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Тав.Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үндэсний Аудитын газрын Хоёрдугаар газрын захирал Ц.Батбаярт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

070384

tushaal

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2008 оны 6 дугаар сарын 25-ны
5 дугаар тушаалын хавсралт

“Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд аудит хийх явцад
2006, 2007 онд олгосон санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт
төвлөрлүүлээгүй зөрчлийн жагсаалт УХА0122

№	Төлбөр хариуцагчийн		Төлбөрийн товч утга	Төлбөрийн дүн (мян.төг)	Барагдуулалт	
	Албан тушаал	Нэр			МУХС	ҮАГ-т шилжүүлсэн
1	Захирал Нягтлан бодогч	Т.Даш-Очир Ц.Ичинхорлоо	СХД-ийн Ирээдүй ЦС-ийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	9,441.2	8,355.0	1,086.2
2	Захирал Нягтлан бодогч	Д.Энхжаргал В.Янжиндулам	СХД-ийн 104-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,468.0	2,468.0	
3	Захирал Нягтлан бодогч	Д.Цэрмаа С.Алтанцэцэг	СХД-ийн 107-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,759.2	2,759.2	
4	Захирал Нягтлан бодогч	Ш.Сарантуяа Ж.Эрдэнэчимэг	СХД-ийн 42-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	4,407.1	4,407.1	
5	Захирал Нягтлан бодогч	Д.Наранцацралт Ч.Нямзагд	СХД-ийн 65-р дунд сургуулийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	5,950.2	5,227.8	722.4
6	Захирал Нягтлан бодогч	Б.Цогзолмаа В.Тунгалагтуяа	СХД-ийн 76-р дунд сургуулийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,539.6	637.2	902.4
7	Захирал Нягтлан бодогч	Э.Алтанцэцэг Б.Шийрэвдорж	СХД-ийн 12-р дунд сургуулийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	4,002.8	3,291.7	711.1
8	Захирал Нягтлан бодогч	Ч.Хишигмаа Я.Оюунбилэг	СХД-ийн 67-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	3,202.7	3,202.7	
9	Захирал Нягтлан бодогч	Д.Намнансүрэн Б.Дагвасүрэн	СХД-ийн 9-р дунд сургуулийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,363.4	727.3	636.1
10	Захирал Нягтлан бодогч	Ц.Даваадоо Г.Бадамцэцэг	СХД-ийн 62-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	731.4	731.4	
11	Захирал Нягтлан бодогч	Р.Дүгэрсүрэн А.Туяа	СХД-ийн 105-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,102.4	1,102.4	
Сонгино хайрхан дүүргийн дүн				36,968.0	32,909.8	4058.2
12	Захирал Нягтлан бодогч	Д.Сэсээр Т.Эгиймаа	Чингэлтэй дүүргийн 5-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,861.6	2,861.6	
13	Захирал Нягтлан бодогч	Ж.Бааст Ц.Ариунцэцэг	Чингэлтэй дүүргийн 17-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	4,155.0	4,155.0	
14	Захирал Нягтлан бодогч	Ж.Чимэдрэгзэн Р.Уранчимэг	Чингэлтэй дүүргийн 24-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,544.6	1,544.6	
15	Захирал Нягтлан бодогч	Ц.Уянга Д.Анхтуяа	Чингэлтэй дүүргийн 23-р дунд сургуулийн 2006-2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,099.6	2,099.6	

16	Захирал Нягтлан бодогч	Ц.Өлзийжаргал Ц.Ариунцэцэг	Чингэлтэй дүүргийн 37-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,158.1	1,158.1	
17	Захирал Нягтлан бодогч	Ж.Ганбат З.Оюунчимэг	Чингэлтэй дүүргийн 39-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,962.0	1,962.0	
18	Захирал Нягтлан бодогч	О.Чимэдцэрэн Л.Болорэрдэнэ	Чингэлтэй дүүргийн 49-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,753.8	1,753.8	
19	Захирал Нягтлан бодогч	Л.Оюунцэцэг Ц.Гантулга	Чингэлтэй дүүргийн 50-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,243.7	2,243.7	
20	Захирал Нягтлан бодогч	С.Мандах С.Бүжинлхам	Чингэлтэй дүүргийн 57-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	747.5	747.5	
21	Захирал Нягтлан бодогч	А.Мөнхчимэг Р.Тунгалаг	Чингэлтэй дүүргийн 61-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	899.6	899.6	
22	Захирал Нягтлан бодогч	З.Чинбат Д.Пүрэвжаргал	Чингэлтэй дүүргийн 72-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,447.2	1,447.2	
Чингэлтэй дүүргийн дүн				20,872.7	20,872.7	
23	Хэлтсий н дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Дашхорлоо Л.Батзориг	ХУД-ийн сургуулиудын зарцуулагдаагүй үлдэгдэл	12,221.0	12,221.0	
Хан-Уул дүүргийн дүн				12,221.0	12,221.0	
24	Захирал Нягтлан бодогч	Ж.Мягмарсүрэн Г.Одончимэг	"КИНГС КИДС" дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,866.6		1,866.6
25	Захирал Нягтлан бодогч	Ц.Гүррагчаа Д.Цэрэнчимэд	1-р сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	508.2		508.2
26	Захирал Нягтлан бодогч	В.Жанцансамбуу Ц.Эрдэнэцэцэг	СБ дүүргийн 6-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,536.0	1,536.0	
27	Захирал Нягтлан бодогч	Ц.Сарангэрэл Л.Цэцгээ	СБ дүүргийн 3-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	598.5		598.5
28	Захирал Нягтлан бодогч	Л.Долгоржав Д.Цэцгээ	СБ дүүргийн 16-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	654.7	654.7	
29	Захирал Нягтлан бодогч	Д.Баяр	СБ дүүргийн "Үй цай" бүрэн дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	517.7		517.7
Сүхбаатар дүүргийн дүн				5,681.7	2,190.7	3,491.0
30	Захирал Нягтлан бодогч	Л.Эрдэнэчулуун Д.Дорждулам	БЗД-ийн 14-р сургуулийн зарцуулагдаагүй үлдэгдэл	1,143.1	1,143.1	
31	Захирал Нягтлан бодогч	Г.Ариунболд Г.Майцэцэг	БЗД-ийн 21-р сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,818.2	1,818.2	
32	Захирал Нягтлан бодогч	Ж.Шараа Д.Ганжимс	БЗД-ийн 88-р сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	757.7	757.7	
33	Захирал Нягтлан бодогч	З.Янжмаа Б.Нэргүй	БЗД-ийн 55-р сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	4,088.7	4,088.7	
34	Захирал Нягтлан	Г.Гүүгэл Г.Цэенпил	БЗД-ийн Шавь цогцолбор дунд сургуулийн 2007 онд	6,987.7	6,987.7	

	бодогч		зарцуулагдаагүй үлдэгдэл			
35	Захирал Нягтлан бодогч	Г.Баттөр Б.Уламбаяр	БЗД-ийн 48-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	6,646.2	6,646.2	
36	Захирал Нягтлан бодогч	С.Марта Б.Эрдэнэчимэг	БЗД-ийн 84-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,464.0	2,464.0	
37	Захирал Нягтлан бодогч	Р.Туяа С.Цэндаюуш	БЗД-ийн 79-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,880.2	1,880.2	
38	Захирал Нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг П.Мядагмаа	БЗД-ийн 87-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	1,272.7	1,272.7	
39	Захирал Нягтлан бодогч	Р.Тэмүүжин Ж.Гантулга	БЗД-ийн Амгалан цогцолбор сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,684.7	2,684.7	
40	Захирал Нягтлан бодогч	С.Энхжаргал Л.Цэцэгмаа	БЗД-ийн 85-р дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	798.0	798.0	
41	Захирал Нягтлан бодогч	Ц.Алтанцэцэг Б.Оюунбат	"Эрэл" дунд сургуулийн 2007 онд зарцуулагдаагүй үлдэгдэл	2,819.3		2,819.3
42	Захирал Нягтлан бодогч	В.Цэцэгээ Д.Цэцэгмаа	БЗД-ийн 53-р дунд сургуулийн 2007 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	1,584.5	1,584.5	
			Баянзүрх дүүргийн дүн	34,945.0	32,125.7	2,819.3
43	Захирал Нягтлан бодогч	Ж.Батцэцэг Ш.Чимэгбаатар	Налайх дүүргийн Голомт ЦС-ийн 2007 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	895.1	895.1	
44	Захирал Нягтлан бодогч	Ш.Баасансүрэн Б.Нямбуу	Багахангай дүүргийн Хангай ЦС-ийн 2007 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	2,749.9	2,749.9	
45	Захирал Нягтлан бодогч	И.Бямбажав П.Амарсайхан	Багануур дүүргийн Болоовсрол ЦС-ийн 2007 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	5,126.7	5,126.7	
46	Захирал Нягтлан бодогч	Ц.Батаа Л.Оюунбат	Төв аймаг, Эрдэнэ сумын МСЕБС-ийн 2007 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	360.3	360.3	
			Бүгд дүн	119,820.4	109,451.9	10,368.5

Үндэсний аудитын 2 дугаар газар

